

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

**“ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО”
СУДАЛГААНЫ ТОЙМ**

Хэвлэн нийтлэгдээгүй анхдагч тайлан

Улаанбаатар, 2010 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
БСШУЯ	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БЗХӨ	БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН
ГХЯ	ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ДОХ	ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДЛЫН ХАМ ШИНЖ
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЗЗХ	ЗАЛУУЧУУДЫН ЗӨВЛӨХ ХОРОО
ЈСІ	ЗАЛУУ ҮЕ ТАНХИМ
ИЗН	ИРГЭНИЙ ЗОРИГ НАМ
МоАЗХ	МОНГОЛЫН АРДЧИЛСАН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО
МАСЗХ	МОНГОЛЫН АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО
МАСОХ	МОНГОЛЫН АРДЧИЛСАН СОЦИАЛИСТ ОЮУТНЫ ХОЛБОО
МАХН	МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ
МЗХ	МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО
МОХ	МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБОО
МХЗЭ	МОНГОЛЫН ХУВЬСГАЛТ ЗАЛУУЧУУДЫН ЭВЛЭЛ
МСҮТ	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ
МХЗ	МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ
НХХЯ	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
ОУБ	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ОУХБ	ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА
ОУСЗХ	ОЛОН УЛСЫН СОЦИАЛИСТ ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО
СТС	СУРГАЛТЫН ТӨРИЙН САН
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
УЗ	УДИРДАХ ЗӨВЛӨЛ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ҮЭ	ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ
ХЭДС	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН
ХДХВ	ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС
ХТГ	ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ГАЗАР
ШУА	ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ШУТИС	ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭШ	ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ
ЭМДС	ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САН
ЭМЯ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

АГУУЛГА

ОРШИЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- 1. “ЗАЛУУЧУУД” ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ? ТОДОРХОЙЛОЛТЫГ ГАРГАХ**
- 2. ЗАЛУУЧУУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, СОРИЛТУУД**
 1. Залуучуудын чанартай боловсрол, мэргэжил эзэмших асуудал
 2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал
 3. Залуучуудын эрүүл мэндийн байдал, чөлөөт цаг
 4. Залуучуудын нийгмийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх
- 3. ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮД, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД**
 1. Залуучуудад чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд
 2. Залуучуудад чиглэсэн бодлого хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд
- 4. ТББ-УУДЫН ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА**
 1. Залуучуудын мэргэшсэн ТББ
 2. Намуудын дэргэдэх залуучуудын ТББ
 3. Залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг бусад ТББ
- 5. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОЙМ ДҮГНЭЛТ**

АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

ОРШИЛ

2000 оны хүн амын тооллогын дүнгээр манай улсын хүн амын 20 хувь нь 15-24 насны залуучууд, 2004 оны байдлаар нийт хүн амын 39.5 хувь нь 15-34 насны залуучууд эзэлж байв.

Хөгжиж буй бусад орны залуучуудын нэгэн адил манай улсын залуучуудад зохистой эрүүл мэнд, боловсрол санхүүгийн үйлчилгээ хүртэх, хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдах, нийгмийн амьдралд тэгш дүүрэн оролцох бололцоог бий болгох зэрэг тулгамдсан асуудлууд оршоор байна.

Юуны түрүүнд залуучууд гэдэгт ямар насны, бүлгийн хүмүүс хамаарах тухай асуудал нэлээн маргаантай, нэгдмэл болж тогтоогүй ойлголт юм. Залуучуудын тухай тодорхойлолт, насны ангилалыг гаргах нь манай төрөөс баримтлах бодлогын цар хүрээ, хэмжээг тогтоох, тэдний насны онцлог байдал, нийгэмд хүлээх эрх, үүрэгтэй уялдсан төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дөхөм болох учиртай.

Манай залуучуудын боловсрол эзэмших, нийгмийн өмнө үүрэг хариуцлага хүлээх, бие даасан хүн болон төлөвших үйл явцад тулгамдаж буй асуудлыг тодорхойлон гаргах нь чухлаар тавигдаж байна. Эдгээр тулгамдаж буй асуудлууд нь өөр хоорондоо нягт холбоотой үүний учир шалтгааныг тогтоох нь түүнийг шийдвэрлэх арга замыг тогтооход тус нэмэр болно.

Өнөөдөр дэлхий дахинд залуучуудын нийгэмд эзлэх байр суурь оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдний төлөөллийн байгууллага, залуучуудын төрийн бус байгууллага, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэхэд анхаарч байна. Иймд манай улсад залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдал, дотоод ардчилал нь бидний сонирхож буй сэдвийн нэг болсон юм.

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш манай төрөөс залуучуудад чиглэсэн хэд хэдэн бодлогын баримт гаргасан бөгөөд эдгээр бодлогын баримтад тусгасан залуучуудад чиглэсэн төрийн бодлого шийдвэр, түүнийг хэрэгжүүлэгч төрийн бүтцэд дүн шинжилгээ хийж бодлогыг ойлгомжтой, үр дүнтэй болгох нь зайлшгүй тулгамдаж байна.

Судлаач миний бие энэхүү судалгааны ажлын хүрээнд залуучуудын талаар тодорхойлолт гаргах, тэдэнд тулгамдаж буй нийгмийн асуудлуудыг тодорхойлох, залуучуудын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, төрийн зүгээс залуучуудад чиглэсэн бодлогод тойм дүгнэлт өгөхийг зорилоо.

Эцэст нь өгүүлэхэд ЗАЛУУЧУУД гэдэг нь нийгэмд тулгамдаж буй асуудал бус тэд нийгмийн хөгжлийг авч явах хүч, нөөц бололцоо юм гэдгийг онцолмоор байна.

Дашрамд нь тус судалгааны ажлыг гүйцэтгэх боломж олгосон Нээлттэй нийгэм форумын хамт олонд талархаж буйгаа илэрхийлье.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Тус судалгааны ажлын зорилго нь залуучууд гэсэн ойлголтонд ямар насны бүлгийн хүмүүсийг хамааруулж болох тухай, эдгээр залуучуудад тулгарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлох, залуучуудтай холбоотой төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, залуучуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж буй төрийн бүтэц, хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар дүн шинжилгээ гаргахад оршиж байв.

Бодлогын тойм судалгааны ажлын хүрээнд дараахь зорилтуудыг тавьж ажиллалаа. Үүнд:

1. Залуучуудад чиглэсэн бодлого, эрх зүйн баримтууд, судалгааны материалтай танилцах;
 2. Залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн тайлантай танилцах;
 3. Залуучуудад тулгамдаж буй асуудлаар оюутан, залуустай ганцаарчилсан ярилцлага хийх;
 4. Гадаад улсуудын залуучуудын талаар баримталж буй бодлого, жишээ тохиолдолтой (кэйс) танилцах;
 5. Судалгааны тайлан бичих, үр дүнг боловсруулах, дүгнэлт гаргах;
- зэрэг болно.

1. “ЗАЛУУЧУУД” ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ? ТОДОРХОЙЛОЛТЫГ ГАРГАХ

Хүний насны ангилал тэр дундаа залуу насны хүн гэсэн тодорхойлолтыг шинжлэх ухааны хувьд тухайн бүлэгт хамаарах хүний биологи физиологийн онцлог, нийгэмд эзлэх байр суурь, нийгэмшилт, амьдралын түвшин, үзэл бодлын төлөвшилт, сэтгэлзүйн төлөв байдал зэргээс хамаарч харилцан адилгүй тогтоож тодорхойлсон байна.

Нийгмийн шинжлэх ухаанд ерөнхийдөө тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагын чадвар бий болсон эсэх, нийгэмшил, эд хөрөнгө, албан тушаал г.м шалгуураар хүний насны ангилалыг тодорхойлон гаргадаг.

Гэвч хүн нийгмийн амьтан болохын зэрэгцээ оюун ухаан (сэтгэлийн), мах, цусан тогтоц бүхий биологийн төрөл зүйл мөн учир бие, сэтгэхүйн хөгжлийг шалгуур болгон авч үзэх нь зүйтэй. Тодруулбал, нийгмийн ухааны үүднээс хүний насыг ангилахдаа бие бялдар, сэтгэхүйн хөгжил, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх үе буюу бие даан эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар гэсэн хүчин зүйлсийн гурвалсан давхцлаар тодорхойлдог байна¹.

Залуу насны тодорхойлолтыг дээрхи зарчимд тулгуурлан гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь залуу хүн бие физиологийн хувьд боловсорч гүйцэх, нийгмийн харилцаанд суралцаж, бие даасан эрх үүрэгтэйгээр оролцож эхлэх боловч оюун сэтгэхүйн хувьд бүрэн төлөвшөөгүй байх нарийн зааг үе шатанд байдаг.

Гэхдээ залуу насны ангилалыг гаргахдаа түүнийг хүүхэд нас болон насанд хүрсэн хүнээс ялган салгаж ойлгох нь нэн чухал бөгөөд залуу насны доод, дээд хязгаар болох шилжилтийн үеийн өсвөр нас, насанд хүрэх шилжилтийн үеийн насыг тодорхойлоход судлаачдын дунд нэлээд зөрүүтэй санал дүгнэлтүүд байдаг байна.

Судлаач Д.Цогзолмаагийн (*ШУТИС-ийн сэтгэл судлалын багш*) судалгааны ажлаас үзэхэд монголчуудын уламжлалт ойлголтоор насны ангилалыг дараахь байдлаар тодорхойлсон байна.

1. нялх үе /0-3/
2. балчир нас /3-7/
3. бага нас /8-12/
4. өөлийхүү буюу өсвөр нас /13-17/
5. орь залуу нас /18-25/
6. залуу нас /25-35/
7. идэр нас /35-45/
8. хижээл нас /45-60/
9. өтөл нас /60-80/
10. өндөр нас /80-аас дээш/

¹ <http://biznetwork.mn/network/topic/show/8949/page/1> - Залуу насны ангилалын талаарх бэсрэг шинжилгээ

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

Энэхүү ангиллаар өсвөр наснаас залуу нас хүртэлхи буюу 13-35 насны хүмүүсийг одоо цагийн залуу хүн гэсэн ангилалд хамааруулж үзэж болохоор байна.

Монгол хэлний тайлбар тольд² орь насанд 18-25, залуу насанд 25-35 насны хүмүүсийг багтаан оруулсан нь дээрхи судалгааны ангилалтай давхцаж байна.

Монгол улсын эрхзүйн баримт бичгүүдэд залуу насны ангиллыг тодорхойлоход хамаарах дараахь томъёоллууд байдаг. Тухайлбал:

- Монгол Улсын Үндсэн хуульд иргэний сонгох эрхийг 18 наснаас эхлэн эдэлж төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй гэж заасан байна.
- Монгол улсын Иргэний бүртгэлийн тухай хуульд тус улсын иргэн мөн болохыг батлан гэрчлэх иргэний үнэмлэхийг 16 нас хүрсэн иргэнд шинээр олгоно гэж заасан.
- Иргэний хуульд 18-аас дээш насны хүнийг өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвартай насанд хүрсэн буюу иргэний эрхзүйн бүрэн чадамжтай гэж үзсэн байна³. Мөн 16-18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно гэжээ. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно. Харин насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна гэж заасан. Бүрэн бус чадамжтай гэдэг нь өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах, энэхүү орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах, өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх эрхтэй гэж заажээ.
- Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд асран хамгаалуулж байгаа хүүхэд 14 нас хүрмэгц асран хамгаалагч нь харгалзан дэмжигчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Тэтгүүлэгч хүүхэд 18 нас хүрсэн тохиолдолд тэжээн тэтгүүлэх эрх нь дуусгавар болно гэж туссан байна.
- Монгол Улсын Эрүүгийн хуульд “Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэжээ. Харин 14-16 насны этгээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн заалтууд болох хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах зэрэг зүйл заалтад заасан хүнд болон онц хүнд хэргийг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

² Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь

³ Монгол Улсын Иргэний хуулийн 14-15-р зүйл

- Хөдөлмөрийн тухай хуульд насанд хүрсэн буюу 18 наснаас дээш насны иргэний хөдөлмөрийн харилцааг тусгасан бөгөөд 14-18 насны иргэнийг хөдөлмөрийн харилцаанд түүнд тохирсон эрх, үүрэгтэйгээр оролцохоор заажээ. Тухайлбал, долоо хоногийн ажлын үндсэн цаг нь 18-аас дээш насны иргэний хувьд 40 хүртэл цаг байхаар заасан бол 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны ажилтанд 36 цаг хүртэл байна гэж заасан байна. Үүнээс үзэхэд 14 нас хүрсэн Монгол улсын иргэн хөдөлмөрлөх ажиллах эрхээр хангагдаж энэ төрлийн эрхзүйн харилцаанд орохыг хуулиар зөвшөөрч байна.
- Монгол Улсын Даатгалын тухай хуульд зааснаар 0-16 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг улсаас даахаар заасан ба түүнээс дээш насны хүмүүс ажил хөдөлмөр эрхлэлтээс олсон орлогоосоо албан болон сайн дурын даатгалыг төлөхөөр тусгагджээ.
- Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах хуульд 0-18 насны хүмүүст тус хуулийн үйлчлэл хамаарахаар заажээ. Гэвч хууль эрхзүйн баримтуудын хоорондын ойлголт, томъёоллын зөрүүг арилгах үүднээс энэхүү хуулийг Хүүхэд, өсвөр насны залуучуудын эрхийг хамгаалах хууль болгох эсвэл 0-14 насны хүүхдийн эрхийг хамгаалахаар заах нь зүйтэй санагдана.
- МУ-ын Үндэсний статистикийн хорооноос 2000 онд олон улсын стандартын дагуу гаргасан амьдралын мөчлөгөөр бүлэглэсэн ангилалд 15-24, 25-34 насны бүлэглэлийг багтаасан байна. Харин 2010 онд НХХЯ-аас гаргасан “Хүн ам нийгмийн хамгаалал хөдөлмөрийн үзүүлэлт”-д хүн амын бүлгийг 0-14, 15-59, 60 дээш насны гэж авч үзсэн байна. Энэхүү статистик баримтанд хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүчний судалгаанд 16-59 насны эрэгтэйчүүд, 16-54 насны эмэгтэйчүүдийг авч үзсэн бөгөөд АНУ, Англид манай улстай адил 16 наснаас эхлэн, харин Япон, Герман, Итали, Франц зэрэг улсуудад 15 наснаас эхлэн тус судалгаанд хамруулан авч үздэг байна⁴.

Дээрхи Монгол Улсын холбогдох хуулийн баримт бичгээс үзэхэд иргэн хүнийг 14-16 наснаас эхлэн бүрэн болон бүрэн бус чадамж, эрхтэйгээр эрхзүйн харилцаанд орж болохыг тодорхойлон заасан байна.

НҮБ-ын бодлогын баримт бичгүүдэд⁵ туссанаар залуучуудын стандарт тодорхойлолтонд 15-24 хүртэлх насны хүмүүсийг багтаасан байдаг. Гэвч дэлхийн улс орнуудын хүүхэд залуучуудын талаархи тодорхойлолтууд насны хувьд харилцан адилгүй буюу 7-39 насны хооронд байна. Жишээлбэл, Угандад 12-30 насны хүмүүсийг, Нигери, Бангладешид 18-35 насны хүмүүсийг залуучууд гэсэн тодорхойлолтонд багтаасан байна. Ерөнхийдөө залуучуудыг тодорхойлохдоо амьдралын мөчлөгийн хувьд нас биед хүрэх хүртэлхи хугацаа, тухайлбал сургууль төгсөх дундаж нас, насанд хүрсэн хүний нийгэмд үүрэг гүйцэтгэж эхлэх дундаж нас зэрэг хүчин зүйлсийг харгалзан авч үздэг байна.

⁴ НХХЯ – Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлтүүд, 2010 он.

⁵ ОУХБ, НХХЯ - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаархи ОУХБ-аас гаргасан баримт бичгийн эмхэтгэл 2006 он, 48 нүүр

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

Европын холбооны “Залуучуудын хөтөлбөр”-г⁶ залуу насны ангилалд 15-28 (зарим тохиолдолд 13-30) насны хүмүүсийг багтаан хамруулжээ.

Манай улсын “Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т өсвөр болон залуу насны ангилалд хамаарах насны бүлгийг тодорхойлоогүй боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь 10-35 насныханд чиглэсэн үйл ажиллагааг багтаасан байв.

Манай улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг намуудын дэргэдэх залуучуудын байгууллагууд болон томоохон залуучуудын төрийн бус байгууллагуудын гишүүнчлэлийн насны дээд хязгаар нь гол төлөв 35 нас байна.

Эдгээрээс үзэхэд залуу насны ангилалд багтаж болох хүмүүс 15-35 насны хооронд хэлбэлзэж байна.

Үүнээс үндэслэн залуучуудын насны доод хязгаарыг 15, дээд хязгаарыг 35 нас гэж үзэж болох юм. Учир нь, залуу насны доод хязгаар гэж үзэж болох 15 насанд энэ насныхан сэтгэхүйн болон биеийн хөгжил, нийгэмшилтийн хувьд бусдад хүлээн зөвшөөрөгдөж, аливаад бие даан оролцох, хувийн байр суурьнаас хандах чадвар эзэмшин, хариуцлага хүлээх, биеийн хүчний хувьд ачаалал даах чадвартай болохын зэрэгцээ эрх зүйн чадамж бүрддэг. Харин залуу насны дээд хязгаарын тухайд сэтгэхүйн хөгжил тогтворжих, нийгмийн харилцааны туршлага, нийгэмд эзлэх байр суурь харьцангуй төлөвших, үхэл хагацал, төрөлт, гэрлэлт зэрэг хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд бусад насныхантай харьцуулахад өсөх үе тул залуучуудын насны дээд хязгаарыг 30-35 насны хооронд байна гэж үзэж болно. Энэ нь манай нийгмийн янз бүрийн бүлгийн хүлээн зөвшөөрч бий болгосон ойлголттой ерөнхий байдлаараа давхцаж байгаа юм.

Залуу насны ерөнхий ангиллын зэрэгцээ түүний дотоод ангилалд хамаарах өсвөр нас, орь залуу нас, залуу насны ангилалын заагийг гаргах нь хөндөх ёстой асуудлын нэг юм.

⁶ http://ec.europa.eu/youth/youth-in-action-programme/doc74_en.htm

2. ЗАЛУУЧУУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, СОРИЛТУУД

Манай залуучуудын хувьд өнөөдөр тулгамдаж буй гол сорилт нь бусад хөгжиж буй орнуудын залуусын нэгэн адил ажлын байртай болох, чанартай боловсрол эзэмших, тэдний нийгэмд эзлэх байр суурийг бий болгох, эцсийн дүндээ гэр бүл зохион бие даан амьдрах чадвар бүхий насанд хүрсэн хүн болох явдал юм.

Ардчилсан залуучуудын холбооноос явуулсан “Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудал” сэдэвт судалгааны дүнд залуус өөрсдөд нь тулгарч буй гол хүндрэл бэрхшээлийг ажилгүйдэл, архидалт, боловсролын чанар муу, орон байргүй байх, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх газаргүй байх явдал хэмээн нэрлэсэн байна.

Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан бодлогын баримт бичиг, судалгааны материалуудаас үзэхэд залуучуудад тулгамдаж буй асуудлыг дараахь 4-н үндсэн чиглэлд авч үзэж болохоор байна. Үүнд:

1. Залуучуудын чанартай боловсрол, мэргэжил эзэмших асуудал
2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал
3. Залуучуудын эрүүл мэндийн байдал, чөлөөт цаг
4. Залуучуудын нийгмийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх

1. Залуучуудын чанартай боловсрол, мэргэжил эзэмших асуудал

Залуучууд, өсвөр насныхан нийгэмд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, тогтвортой амьжиргаа орлоготой байхад чанартай боловсрол, мэргэжил, ур чадварыг эзэмшсэн байх шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна.

Гэтэл судалгааны дүнгээр⁷ 15-29 настай мөртлөө боловсролгүй залуучууд байсаар байна. Боловсролгүй нийт залуучуудын 59.8 хувь нь хөдөөд, 21,0 хувь нь сумын төвд, 7,0 хувь нь аймгийн төв дээр, 12,1 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Боловсролгүй, бага болон суурь боловсролтой залуучуудын 51,2-68,7 хувийг эрэгтэйчүүд эзэлж байхад бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой залуучуудын 53,0-62,5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзвэл 15-19 насны залуучууд 38,3 хувь, 20-24 насны залуучууд хамгийн их буюу 40,2 хувь, 25-29 насны залуучууд 38,3 хувийг эзэлж байна. Хөдөөд боловсролгүй болон бага боловсролтой залуучууд давамгайлж байгаа бол хотод, бүрэн дунд, тусгай мэргэжлийн, дээд, магистр ба түүнээс дээш боловсролтой залуучууд ихэнхи хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан суралцаж буй залуусыг бүс, нутгаар авч үзвэл 15-19 насныхны хувьд Улаанбаатар хотод сургуульд хамрагдалт хамгийн өндөр байхад, зүүн бүсэд хамгийн бага хамрагдалттай байна.

Бүрэн дунд боловсролтой залуучуудын эзлэх хувийн жин хотод хөдөөгийнхөөс илүү байгаа нь хөдөөд суурь боловсрол эзэмшээд цаашид үргэлжлэн суралцаж чадаагүйтэй холбоотой.

Бүрэн дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, мэргэжил дээшлүүлэх (албан бус сургалтуудыг оруулан) болон шинжлэх ухаан, судалгаа

⁷ 2007 оны Үндэсний Статистикийн газрын “Сургуулиас ажилд шилжигчдийн судалгааны үр дүн”

шинжилгээний чиглэлд сурч боловсорч буй оюутан, залуучуудад нийтлэг тулгарч буй сургалтын орчин, чанарын асуудал, сургалтын төлбөр, тэтгэлэг тэтгэмж, орлогын байдал гэсэн тулгамдаж буй асуудлыг тус судалгааны хүрээнд авч үзэхийг зорилоо.

Сургалтын орчин, чанар

Өнөөгийн байдлаар нийт 160 мянга гаруй оюутан залуус 140 гаруй улсын болон хувийн их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байна. Зөвхөн нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй болон бүртгэлгүй 1 сая гаруй хүн амьдарч байгаагаас 130 гаруй мянга нь оюутан, 40 гаруй мянга нь ерөнхий боловсролын сургуулийн хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн ахлах ангийн сурагчид байна. Мөн нийслэл хотод хөдөө орон нутгаас их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 60 орчим мянгад хүрсэн бөгөөд энэ тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай болж байна.

Монгол улсад жилд дунджаар 30.000 оюутан их, дээд сургууль төгсөж, мөн төдийн чинээ ЕБС-ийн сурагчид оюутан болж байна.

Дотоодын эрчимтэй шилжилт хөдөлгөөн бий болсон нь нэгэнт ачааллаа даахгүй байгаа Улаанбаатар хот болон суурин газруудад нэмэлт бэрхшээлийг бий болгож, энэ нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна. Шилжин ирэгсдийн хот, суурин газруудын сургуулиуд 3 ээлжээр ажиллах, нэг ангид 40-50 гаруй сурагчид хичээллэх, “харьяаллын бус”, “хамран сургах тойргийн бус” хэмээн тодотгогдсон хүүхдүүд шилжин ирсэн газрын сургуульдаа ачаалал хэтэрсний улмаас гэдэг шалтгаанаар суралцаж чадахгүй байх, сургууль завсардах бэрхшээлүүд үүсэн бий болоод байна⁸. Сургууль завсардалт хөдөөд илүү байгаа бөгөөд сургууль завсардсан хүүхдүүдийн 43,8 хувь нь амьдралын гачигдал, ажил эрхлэх шаардлагын улмаас сургуульд хамрагдаагүй гэжээ⁹. Ядуурлын улмаас хүүхдийнхээ хувцас, хичээлийн хэрэгсэл худалдан авч чадахгүй байгаа өрхийн тоо өсч, хөдөө орон нутагт ядуу өрх хүүхдийнхээ байр, хоолны зардлыг төлж чадахгүй болсон зэрэг нь сургууль завсардалт өсөхөд нөлөөлж байна. Ядуу, нэн ядуу өрхийн сургуулиас гадна байгаа хүүхдийн эзлэх хувь хэмжээ чинээлэг өрхийнхээс бараг 2 дахин их байна.

Манай улсын дээд боловсролын салбар хэт өрөөсгөл бизнесийн хэлбэртэй болж, иргэдийн ойлголтын дутуу байдал, хүүхдээ сургуульд сургах, дээд боловсрол эзэмшүүлэх нийтлэг ашиг сонирхол, сурагчийн төлбөрийн бүрэн чадамжгүй байдал, төрөөс барьж буй “аргацаасан” бодлогыг ашигласан чанаргүй улс, хувийн их, дээд сургуулиуд олноор бий болсон нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй боловсон хүчин бэлдэх, хувь хүний хувьд чадавхи, чадамжгүй “боловсрол эзэмшсэн” залуус олноор бэлтгэгдэн гарах шалтгаан болж байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний эдийн засгийн бүтэц, онцлогтойгоо нийцсэн мэргэжилтэн бэлтгэх төрийн бодлого алдагдсантай шууд холбоотой.

⁸ БСШУЯ, Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө

⁹ Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр

Мэргэжилтэн бэлтгэгч их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын үйл ажиллагаа орчин үеийн чиг хандлагаас хоцорсон, сургалтын хөтөлбөр, арга техник нь цаг үеэ даган шинэчлэгдээгүй, оюутнуудад мэдээлэх өгөх, ном, сурах бичгээр хангах оновчтой тогтолцоо бүрдээгүй, ихэнхи тохиолдолд сурах орчин ачааллаасаа хэтэрсэн гэсэн дүр төрхтэй байна.

Нэг талаас их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр нь онол талдаа илүүтэйгээр тулгуурласан нь оюутныг бодит амьдрал, үйлдвэрлэлээс холдуулж, сургуулиа төгсөөд ажлын байранд дээр гарсныхаа дараа мэргэжилдээ суралцах жишээ баримт олон байна. Нөгөө талаас онол, практикийг хослуулан сургах үйл ажиллагааг дэмжихэд хөрөнгө оруулалт, талуудын ашиг сонирхол байхгүй, сургууль аж ахуйн нэгж, үйлдвэрийн байгууллагын хооронд дундын эрх ашиг, сонирхолд нийцсэн хамтын ажиллагаа дутагдаж байгаа нь чадавхитай залуу боловсон хүчин гаргах боломжгүйд хүргэж байна.

Нийгэмд ноёлон тогтсон нийтлэг уур амьсгалын дагуу эцэг эх, мэргэжлээ сонгож байгаа залуус сонирхолынхоо өрөөсгөл чиг хандлагад хөтлөгдөн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ байхгүй удирдах боловсон хүчин, нийгмийн ухааны мэргэжлийг ихээр сонгох төлөв хадгалагдсаар байна. Үүнийг төрөөс зохицуулах бодлогууд уялдаагүй, ойлгомжгүй байсаар байна.

Өнөөдөр манай их, дээд сургуульд суралцагсдын 15 хувь нь инженер технологи, 3 хувь нь байгалийн шинжлэлийн чиглэлээр сурч байгаа нь эдийн засгийн шинэчлэл хийх, аажмаар мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихээр тунхагласан стратегийн бодлоготой төдийлэн нийцэхгүй байна¹⁰.

Манай оронд шинжлэх ухаан, технологийн боловсролын төвшин доогуур, шинжлэх ухаан, технологи, боловсролын чиглэлд төрийн болон хувийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэн хангалтгүй байна. Нэг оюутанд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээг бусад оронтой харьцуулах тоон үзүүлэлтийг энэхүү судалгааны явцад олж авч чадаагүй ба магадгүй ийм төрлийн судалгаа хийгдээгүй байх магадлалтай.

Оюутан залуусын хувьд сурах, амьдрах орчин тэдний хувьд хүндрэлтэй асуудлын нэг байсаар байна. Ялангуяа дотуур байрны хүрэлцээ, хүртээмж бага, үйлчилгээний чанар тааруу байгаа явдал, оюутан залуусын суралцах үйл явцад сөргөөр нөлөөлж байна. Дотуур байранд орж чадаагүй оюутан залуусын хувьд төрөөс үзүүлэх дэмжлэгийн бодлого байхгүй байгаа бөгөөд ярилцлагад орсон оюутнуудын ярианаас үзэхэд бие даасан хүн болон төлөвших үйл явцад энэ нь ихээхэн бэрхшээл саад болдог талаар өгүүлж байв.

Сургалтын төлбөр, тэтгэлэг тэтгэмж, орлогын байдал

Сургалтын төлбөр нь оюутан залуусын хувьд нэг гол хүндрэлтэй асуудал болдог. Сүүлийн жилүүдэд сургалтын төлбөр жил ирэх бүр тогтвортой нэмэгдсээр ирсэн. Тухайлбал 2010 оны байдлаар төрийн өмчийн их дээд сургуулийн 1 хичээлийн жилийн төлбөрийн хэмжээ дунджаар 950 мянгаас 1 сая төгрөгийн

¹⁰ БСШУЯ, Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө

хооронд хэлбэлзэж байгаа буюу өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 16 хүртэл хувиар өсчээ.

Сургалтын төлбөрийг хэн төлж байгаа талаар судалгаанд¹¹ оролцогчдоос сонирхож үзэхэд төрийн сангийн тэтгэлгээр 10.8 хувь нь, төрийн албан хаагчийн нэг хүүхдийг төрөөс даах тэтгэлгээр 5.7 хувь, буцалтгүй тусламжаар 2.7 хувь, нөхөр, эхнэр нь 1.0 хувь, эцэг, эх, хамаатан садан нь 72.7 хувь, өөрөө 1.6 хувийг төлж байгаа гэсэн дүн гарсан байна.

Сургалтын төрийн сангаар дамжуулан хувийн болон төрийн хэвшлийн их дээд сургуульд суралцагч оюутан залуусын нэг хэсэг бүлэгт нь түүний нийгмийн байдлаас хамааруулж, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, төрийн албан хаагч гэр бүлийн 1 хүүхдийг сургалтын төлбөрөөс чөлөөлөх гэсэн санхүүгийн тусламжийг төрөөс олгож байна.

Энэ нь олон нийтийн дунд нэлээд эерэг, сөрөг үзэл бодлыг дагуулж байна. Учир нь тэтгэлэг олгох шалгуур нь оюутны сурлагын амжилт, идэвхи санаачлагатай төдийлөн холбогддоггүй, зээл тусламж авагчид хариуцлага хүлээлгэх шалгуур үзүүлэлтүүд тодорхойгүй, тэтгэлэг зээл олгох үйл явц ил тод бус байдаг талаар ярилцлагад орсон оюутан залуус, судлаачид дурдаж байв.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын сургалтын зардлыг төрөөс хариуцаж ирсэн ба 2008 оны эхнээс суралцагчдад тэтгэлэг (сард 45 мянга, жилд 450 мянган төгрөг) олгох болсноор энэ чиглэлээр суралцагчдын тоо нэлээд нэмэгдэх хандлагатай байна.

Оюутан залуустай хийсэн ярилцлагаас үзэхэд тэдний сарын хэрэглээ дунджаар 100 мянган төгрөгөөс 150 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Ярилцлагад орсон оюутан залуусын хариултаас үзэхэд тэдний гарын мөнгийг гол төлөв эцэг эх, хамаатан садан нь өгдөг аж. Гэтэл нийгэмд эзлэх байр суурь, эрэлт хэрэгцээ нь улам бүр нэмэгдэж буй, бие даасан залуу хүний хувьд өөрийн гэсэн тодорхой орлоготой байх явдал тэдний хувьд амин чухлаар тавигддаг боловч энэхүү минималь хэрэгцээг хангах бодитой, тогтвортой орлогогүй байна. Оюутныг хичээлийн бус цагаар нь болон амралтаар нь түр хөдөлмөр эрхлүүлж тэдний орлогыг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх тогтолцоо (институтчилал), тодорхой эрх зүйн баримтууд байхгүй байна. Сургалтын чанар, хүртээмж тааруу, оюутны хөдөлмөр эрхэлж орлого олох боломж муу байгаа зэргээс үүдэн оюутан, суралцагчдын суралцах идэвхи буурч, чөлөөт цаг ихтэй болж, гэмт хэрэг зөрчилд холбогдох, дэмий сэлгүүцэн, цагийг үр дүнгүй өнгөрөөн, зугаа цэнгэлд автагдах, улмаар амар хялбараар мөнгө олох, амьдрах хүслийг бий болгосноор нийгэмд олон сөрөг үр дагаврыг үүсгэсээр байна.

Иймд оюутан залуучуудын өөрийн хэрэгцээгээ хангах, бие даасан хүн болон төлөвшихөд шаардлагатай тодорхой орлогыг бий болгох төрийн бодлого үгүйлэгдэж байгаа нь тулгамдаж буй асуудлын нэг болжээ.

2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал

¹¹ 2007 оны Үндэсний Статистикийн газрын “Сургуулиас ажилд шилжигчдийн судалгааны үр дүн”

Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт

Монгол Улсын хүн амын насны бүтцийг дэлхийн бусад орны хүн амын насны бүтэцтэй харьцуулахад харьцангуй залууд тооцогдох бөгөөд 2000 оны хүн амын тооллогын дүнгээр манай улсын 5 хүн тутмын нэг нь 15-25 насны залуучууд, 2008 оны байдлаар нийт хүн амын 39,5 % нь 15-34 насны залуучууд байна.

Манай улсын хувьд нийт ажиллагчдын дунд залуучуудын эзлэх хувь тогтмол буурах хандлагатай байгаа боловч ажиллах хүчний дунд 25 хүртэл насны залуучуудын эзлэх хувь 23,3%, 35 хүртэл насны залуучуудын эзлэх хувь 54,3% байна.

“Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал” үндэсний илтгэлд дурдсанаар хотын залуучууд хөдөөгийн залуучуудтай харьцуулахад ажиллах хүчний оролцооны түвшингээрээ доогуур байгааг харуулдаг.

Азийн Хөгжлийн Банкны тусламжтайгаар Үндэсний статистикийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд манай улсад 2004 оны 5 дугаар сарын 24-ний байдлаар нийт 69263 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгджээ. Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн тоонд 15-24 насны залуучууд 16,1 хувь, 25-34 насны залуучууд 18,6 хувийг эзэлж байсан буюу 15-34 насны залуучууд хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 34,7 хувийг эзэлж байв.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн хүндрэл, бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт бага байгаатай холбогдон дотоодын хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний илүүдэл гарах болсон. Гадаад харилцааны яамны 2010 оны мэдээллээр Монгол Улсын 200 гаруй мянган иргэн гадаадад сурч, ажиллаж, амьдарч байна.

НХХЯ, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэгийн хамтарсан “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” сэдэвт судалгааны тайланд нийтэлсэн түүвэр судалгаагаар БНЧУ-д очсон иргэдийн 92,5 хувь, БНСУ-д очсон иргэдийн 96,4 хувь, АНУ-д очсон иргэдийн 87,3 хувь ажил эрхэлж байна. Судалгаанд хамрагдагсдын 44,2 хувь нь хөдөлмөрийн гэрээтэй, дийлэнхи нь хүнд, хортой нөхцөлд, өдөрт 10-12 цаг ажилладаг байна. Дундаж цалин нь 1115 ам.доллартай тэнцүү байна. Гадаадад ажиллагч монголчууд тухайн улсын иргэдтэй харьцуулахад 1,4 -1,6 дахин бага цалин авч байна. Гадаадад ажиллагч монголчуудын дийлэнхи нь гэрийн үйлчлэгч, асрагч, барилгын ажилчин, оёдолчноор ажиллаж байна. Мэргэжилгүй хүмүүс гадаадад ажиллагчдын дунд нэлээд хувийг эзэлж байна. Жишээлбэл, БНЧУ-д ажиллагчдын бараг тал нь мэргэжлээрээ ажиллаж байхад БНСУ-д ажиллагчдын дөнгөж 16 хувь, АНУ-д ажиллагчдын 10 орчим хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа ажээ. “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны тайлангаас тооцоолж үзэхэд судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 24,3-37,3 хувь, эмэгтэйчүүдийн 18,5-20,6 хувь нь мэргэжилгүй хүмүүс байв. Тус судалгаанд дурдсанаар гадаадад ажиллагчдын дийлэнхи нь 20-35 насны бүлэгт хамрагдах хөдөлмөрийн насны залуу хүмүүс байгаа бөгөөд тэдний дундаж нас 31,3 байна.

Нийгэмд, ялангуяа зах зээлийн эдийн засгийн нийгэмд ядуурал, гэмт хэргийн өсөлт, архидалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл нэмэгдэхэд ажилгүйдэл голлох нөлөө

үзүүлдэг. Ажилгүйдэлд залуучууд илүү өртөмтгий байдаг. Тухайлбал, Үндэсний статистикийн газраас Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2002-2003 онд анх удаа явуулсан ажиллах хүчний суурь судалгааны дүнгээс үзэхэд залуучуудын ажилгүйдлийн түвшин хүн амын бусад насны бүлгийнхэнтэй харьцуулбал өндөр байна. Үүнд улсын дунджаар ажилгүйдлийн түвшин 14,2 хувь байгаа бол 15-19 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 18 хувь, 20-24 насны залуучуудынх 21,2 хувь, 25-29 насны залуучуудынх 14,4 хувь, 30-34 насны залуучуудынх 13,5 хувь байв.¹² Хөдөлмөр эрхлэлтийн албадад бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 57,2 нь 16-35 хүртэл насны залуучууд (үүний дотор 23,5 хувь нь 16-24 насны залуучууд, 33,7 хувь нь 25-34 насны залуучууд) байна. Иймд хөдөлмөр эрхлэлтийн асуудлын хүрээнд 15-24 насны залуучуудыг онцгой бүлэгт хамааруулж болох юм. Мөн хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудын дийлэнхи олонхи нь албан бус секторт ажилладаг байна.

Хотын 15-34 насны залуучуудын хувьд ажилгүйдлийн түвшин хүйсийн хувьд бараг ялгаагүй, гэхдээ 15-19 насны бүлгийн залуучууд хамгийн их ажилгүйдэлд (ажилгүйдлийн түвшин нь 44,6 хувь) өртөж байна. Хотын 20-24 насны залуучуудын хувьд ч ажилгүйдлийн түвшин өндөр (34,6 хувь) байна. Улаанбаатар хотод 2009 оны байдлаар 123307 ажилгүй хүн байгаагаас 40.1 хувь нь 16-34 насны залуучууд байна. Хөдөөгийн залуучуудын хувьд 20-24 насны залуучуудын ажилгүйдэл харьцангуй их, 25-34 насны залуучуудынх харьцангуй бага байгаа онцлог ажиглагдаж байна.

Залуучууд ажилгүй болох гол шалтгааны нэг нь хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээгүй мэргэжил эзэмших явдал болж байна.

Хөдөлмөрийн зах зээл дээрх мэргэжлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын ажлын байранд тавих шаардлага зэрэг мэдээлэл нь боловсролын байгууллагуудад хүрдэггүй, боловсролын байгууллагууд нь хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээг харгалзалгүй мэргэжил олгож үйл ажиллагаагаа явуулдаг зэрэг нь их, дээд сургууль төгссөн залуучууд ажилгүй болох үндсэн нөхцөл болж байна.

Мөн 9-11-р анги төгсөгчдөд хөдөлмөрийн зах зээл дээр ямар ажил, мэргэжил эрэлт хэрэгцээтэй байгаа талаар нэгдсэн мэдээлэл өгөх байгууллага, үйлчилгээ байхгүй байна.

Бүрэн дунд ба түүнээс дээш түвшний боловсролтой боловч ажилгүй байгаа хүмүүс нийт ажилгүйчүүдийн 64,2 хувийг эзэлж байна. Ажилгүй арван хүн тутмын нэг нь дээд боловсролтой хүн байна. Харин бүрэн бус дунд боловсролтой болон дээд боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин хүн амын бусад бүлгийнхнээс харьцангуй дээгүүр буюу нийт ажилгүй залуучуудын 43 хувийг эзэлж байна.

Боловсролын түвшин доогуур байх (боловсролгүй, бага боловсролтой, бүрэн бус дунд боловсролтой) тохиолдолд залуу эрчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр, харин боловсролын түвшин ахих тутам (бүрэн дунд ба түүнээс дээш) эсрэгээр залуу бүсгүйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрчүүдийнхээс өндөр байгаа нь судалгаагаар гарчээ.

¹² Үндэсний статистикийн газар: *Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан*, Улаанбаатар, 2004, х.46.

МЗХ-ны дэргэдэх Полиси төвөөс хийсэн “Монголын залуучуудын хөгжлийн хэрэгцээ” /УБ., 2003/ судалгаанд харуулсанаар залуучууд хөдөлмөр эрхлэхийн төлөө идэвхи, зүтгэл гаргаж байгаа ч тэдний хүсэл сонирхол, зарим талаар мэргэжил боловсролын түвшин нь хөдөлмөрийн зах зээлд санал болгож буй ажлын байртай нийцдэггүй аж.

Сонирхож буй ажлын байрыг боловсролын түвшинтэй харьцуулбал, дээд боловсролтой ажилгүй залуучуудын 65.6 хувь нь мэргэжлийн дагуу, өмчлөлийн хэлбэрийн хувьд төрийн захиргааны байгууллагад (59.4%, тогтвортой ажлын байр гэж ойлгодог болсон) ажиллах сонирхолтой байгаа бол, тусгай дунд боловсролтой залуусын сонирхож буй ажлын байр нь харьцангуй жигд, бүрэн дунд боловсролтой залуус цалин хөлс өндөр байхыг чухалчилж байна. Одоогийн цалин урамшууллын тогтолцоо, цалингийн түвшин нь автобус, утас, өдрийн хоол гэсэн ойр зуурын хэрэглээнээс илүү гарахгүй байна. Зарим тохиолдолд ажил хийж байгаа нэртэй ч авсан цалингаас нь илүү зарлага гарах тохиолдол байдаг ажээ.

3. Залуучуудын гэр бүл, орон сууцны асуудал

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, хүн ам зүйн бүтцэд гарч буй өөрчлөлтийн нөлөөгөөр монгол гэр бүлийн хэмжээ, бүтэц, уламжлалт харилцаа болон амьжиргааны хэв шинжид олон шинэ хандалгууд бий болж байна. Ялангуяа 90-ээд оноос эхэлсэн эдийн засгийн шинэчлэлийн бодлогын хүрээнд гарсан томоохон өөрчлөлтийн дүнд бий болсон бэрхшээл хүндрэлүүд, тухайлбал үнийн өсөлт, ажилгүйдэл, ядуурал цаашлаад үүнээс үүдэн бий болсон нийгмийн сөрөг үзэгдлүүд нь хүн ам, өрх бүлийн гишүүдийн сэтгэл зүй, харилцаанд нөлөөлж, гэр бүл болох нас хойшлох, төрөлт буурч, гэр бүлийн хэмжээ багасах, гэр бүл салалт нэмэгдэх, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо өсөх, ядуу өрх олшрох хандлагатай болсон.

“Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал”¹³ суурь судалгааны дүнгээр нийт гэр бүлтэй хүн амын 12.8 хувийг хамтран амьдрагч буюу хууль ёсоор гэрлэлтээ батлуулаагүй хүмүүс эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн 20-35 насныхны дунд зонхилж байна. Гэрлэлт нь гэр бүл бүрдэх үндэс бөгөөд энэ нь нийгэм эдийн засаг, зан заншлын онцлогийг агуулсан иж бүрэн ойлголт юм. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн хүрээнд хийсэн томоохон өөрчлөлт шинэчлэлт нь гэр бүл болох уламжлалт сэтгэлгээ, хэв шинжид нөлөөлж, залуучууд гэр бүл болохоосоо өмнө боловсрол эзэмших, ажил эрхлэх, тогтмол орлоготой болохыг нэн түрүүн эрхэмлэх болсон. Залуучуудын албан ёсоор гэрлэлтээ батлуулдаггүй гол шалтгаан нь өөрийн гэсэн орон байргүй байх явдал гэж залуус үзсэн тухай Ардчилсан залуучуудын холбооны хийсэн түүвэр судалгаагаар гарчээ. Өөрөөр хэлбэл залуучууд, залуу гэр бүлийн орон сууцтай болгох талаар төрөөс онцгойлон тодорхой, ойлгомжтой дэмжлэг болох бодлого барьдаггүй¹⁴ нь харагдана.

¹³НХХЯ, “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгаа, -2004 он

¹⁴ www.sonin.mn, 2009оны 09 сарын 21 “МЗХ-ны ерөнхийлөгч Ц.Зоригтбаатараас асуух асуулт” нийтлэл

ШИГТГЭЭ

Өнөөдөр нийгмийн хурдацтай хөгжил, нөгөө талаар амьдралын хүнд бэрхшээл, тулгарч байгаа өч төчнөөн асуудлын үр дүнд гэр бүл гэдэг эрхэм зүйл хаягдаж нэг л мэдэхэд ард үлдчихсэн байх нь энгийн ойлголт болжээ. Тэгвэл бид гэр бүлээ хэрхэн яаж хамгаалах вэ? Амьдралдаа яаж сэтгэл хангалуун амьдрах вэ, үр хүүхдээ хэрхэн өсгөж хүмүүжүүлэх гээд энгийн боловч чухалд тавигдах эдгээр асуултад хариулт олох гэж эрдэг. Бас шаналдаг. Гэвч юу ч хийж чаддаггүй. Ажил ажил, мөнгө цалин гэж гүйсээр эцэст нь маргаан, үл ойлголцол, хүйтэн харьцаа давамгайлж, амьдралаа ямар ч баяр баясгалангүй уйтгартай нэгэн хэвийн байдалд оруулж, өнгө зүсгүй бэлэгдлийн төдий зүйл болгож, эцэстээ юу ч үгүй алдчихсан байдаг. Түүнээс гарах хор уршиг нь ч их байдгийг анзаардаггүй.

Монгол гэр бүлийн өнөөгийн байдал,
<http://www.factnews.mn/news/view/index/id/4231>, 2009.06.08

Очбаяр 28 настай, эрэгтэй

Аливаа зүйл сайн муу хоёр талтай байдаг. Үүний адилаар өнөөдөр бидний амьдарч байгаа нийгэм маань хувь хүн, гэр бүлд маш олон өөрчлөлтийг бий болгосон. Тухайлбал гэр бүлийн гишүүд олон жил хоёр биенээсээ тусдаа ажиллаж, эсвэл суралцаж байна. Залуучуудын гэрлэлтийн нас хойшилж, сурч боловсроход ихэнх цагаа зарцуулж байна. Тэд амьдралын үнэ цэнийг ойлгож, өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөтэй хэнээс ч дутахгүй сайхан амьдрах чадвартай болсон хойноо гэр бүлтэй болохыг илүүд үзэж байна. Мөн залуучуудын гэр бүлийн боловсрол дээшилж, хэзээ хүүхэдтэй болох, үр хүүхдүүдийнхээ ирээдүйн боловсрол мэдлэг зэрэгт эртнээс анхаарах болсон. Гэвч нөгөө талаар нийгмийн тогтолцооны энэхүү “гажиг” гэр бүлийн харилцаанд их багаар нөлөөлж байна. Энэ нь хувь хүний үзэл бодол, зан суртахуун, хүмүүжил мөн эдийн засаг, эрх мэдэл, албан тушаал, эрүүл мэндийн байдал зэрэг юм. Гэр бүлтэй залуучуудын дунд тохиолдож байгаа томоохон дутагдал бол гэр бүлийн үүрэг хариуцлагыг ухамсарлах, аливаа асуудлыг шийдэх чадвар муу, гэр бүлдээ цаг бага зарцуулдаг, чөлөөтэй байхыг илүүд үзэх явдал юм. Энэ нь залуу гэр бүлийн дотор асуудал үүсэх улмаар салах шалтгаан болж байна.

Булган 33 настай, эмэгтэй

Бидний эцэг эхийн үед хүмүүс гэр бүлийн амьдралд их ухамсартай, тэвчээртэй ханддаг байсан шиг санагддаг. Өнөөдрийн чөлөөт ардчилсан нийгэмд гэр бүлийн маш олон хэлбэрүүд бий болжээ. Тухайлбал өрх толгойлсон эмэгтэйчүүд, ажилгүй гэрийн эзэн, бага насны хүүхдээрээ хүнд хүчир ажил хийлгэж өөрсдийгөө тэжээлгэж байгаа эцэг эх, олон жилээр бие биеэсээ тусдаа амьдарч байгаа гэр бүлүүд, баталгаагүй хамтран амьдрагчид, гэр бүлээс гадуур явдал гэх мэт. Үүнээс үзэхэд гэр бүлийн нандин харилцаа алдагдсан юмуу даа гэж боддог.

Дээрхи шалтгаануудаас үүдэн анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж, гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрах хэв шинж хүн амын дунд нэмэгдэх

хандлага ажиглагдаж эхэллээ. 1989 онд гэрлэх насны 4 хүн тутмын нэг, 2000 онд 3 хүн тутмын нэг нь огт гэрлээгүй байгаа буюу гэрлээгүй хүн амын тоо, тэр дундаа залуучуудын тоо өсөн нэмэгдсэн байна. Анхны гэрлэлтийн нас хойшилж, эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 24 насандаа тус тус гэрлэх болжээ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд 43.8 хувь, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 34.8 хувь нь ядуу байна. Ядуу өрхийн 12-17 насны буюу өсвөр насны хүүхэд залуучуудын сургуульд хамрагдалтын түвшин 67 хувь байна.

Боловсролын түвшингээр авч үзэхэд дээд боловсролтой 35-49 насны эмэгтэйчүүдийн 25.0 орчим хувь, 20-34 насны эмэгтэйчүүдийн 46.0 хувь нь өөрөөсөө доогуур түвшний боловсролтой эрэгтэйтэй гэрлэжээ. Дээд боловсролтой хүмүүс арай эрт буюу 24 насандаа гэрлэж байхад бичиг үсэг тайлагдаагүй буюу боловсрол эзэмшээгүй, бага боловсролтой залуучууд 27-30 насандаа гэрлэж, эдийн засгийн идэвхигүй хүн амаас хөгжлийн бэрхшээлтэй залуус 30 насандаа буюу хамгийн орой гэрлэж байна. Энэ нь боловсролтой залуус нийгмийн харилцаанд илүү түлхүү ордогтой холбон тайлбарлаж болно.

2007 оны Үндэсний Статистикийн газрын “Сургуулиас ажилд шилжигчдийн судалгааны үр дүн”-гээс үзэхэд 15-29 насны нийт залуучуудын 217,6 мянга буюу 26,9 хувь нь хүүхэдтэй залуучууд байна. Үүнээс 63,6 хувь нь нэг хүүхэдтэй, 28,9 хувь нь 2 хүүхэдтэй, 1,2-6,2 хувь нь 3-4 хүүхэдтэй байна. Харин боловсролын түвшнээр нь үзэхэд нийт хүүхэдтэй залуучуудын 21,3-30,1 хувь нь суурь, бүрэн дунд болон дээд, 4,1- 4,8 хувь нь тусгай мэргэжлийн дунд болон мэргэжлийн анхан шатны, 3,1 хувь нь боловсролгүй, 0,5 хувь нь магистр ба түүнээс дээш боловсролтой хүмүүс байна.

4. Залуучуудын эрүүл мэндийн байдал, чөлөөт цаг

Залуучуудын эрүүл мэндийн байдал, чөлөөт цаг өнгөрөөж буй хэв маяг нь тэдний боловсрол, нийгмийн байдал, ажил эрхлэлт, орлогын байдалтай шууд холбоотой бөгөөд асуудлыг цогц байдлаар авч үзэх нь илүү чухал байна. Судалгааны явцад авсан эрүүл мэндийн чиглэлийн албан болон албан бус тайлан материалуудад дээрхи асуудлуудыг цогцоор авч үзсэн бага байна.

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрөөс үзэхэд ядуу, орлого багатай хүн ам, залуучуудын хувьд чинээлэг амьдралтай бүлгийн хүмүүсээс бодвол эрүүл мэндийн салбарын үйлчилгээг бага хүртдэг байна. Эрүүл мэндийн үйлчилгээний сарын дундаж зардлыг хэрэглээний түвшингээр авч үзвэл нэн ядуу бүлгийн нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал хамгийн өндөр орлоготой хэсгийнхний зардлаас 9 дахин бага байгаагаас гадна ядуу хүний эмнэлэгт хандах давтамж буурсан дүнтэй байна.

Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн иргэд хоол хүнсний байнгын хомсдолд байж, өлмөн зэлмэн байдалд аж төрж байгаа талаар дээрхи хөтөлбөрт дурджээ. Энэ асуудал нь залуучуудыг бас тойрохгүй бөгөөд монгол хүний өдрийн хоол тэжээлийн илчлэгийн зохистой нормыг 2500-2900 калори гэж тогтоосон байхад ядуу өрхийн гишүүд, зарим оюутан залуус өдөрт дунджаар 2000 хүрэхгүй калори тэжээл авч байна.

Тус судалгааны ажлын хүрээнд ЭМЯ-ны харъяа Эрүүл мэндийн газраас жил бүр гаргадаг “Эрүүл мэндийн үзүүлэлт”-ийн сүүлийн 2 жилийн тайлантай танилцлаа. Тайлангийн судалгаанаас харахад өсвөр насны хүүхдийн (15-19 насны) өвчлөлийн тэргүүлэх шалтгаанаар амьсгалын болон хоол боловсруулах эрхтэн, шээс –бэлгийн тогтолцооны эмгэгүүд илүүтэй тохиолдож байна. Амьсгалын болон хоол боловсруулах эрхтэний өвчлөл хүүхэд насныханд бас тэргүүлэх шалтгааны өвчлөл болж байгаа бөгөөд өсвөр үеийнхний дунд шээс бэлгийн тогтолцооны өвчин илүүтэй илэрч байна. Мөн 20-44 насны хүмүүсийг нэг насны бүлэгт авч үзсэн тус судалгаанд энэ насныханд шээс бэлгийн тогтолцооны өвчин голлох өвчлөлийн шалтгаан болж байгааг дээрхи үр дүнтэй нэгтгэн үзэхэд өсвөр үе, залуучуудад бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ болон зонхилон тохиолдож байна.

Монгол Улс ХДХВ/ДОХ-ын халдварын тархалтын түвшингээр Зүүн Азийн улс орнууд дотор тархалт багатай улсын тоонд багтах боловч сүүлийн жилүүдэд тус өвчний бүртгэгдсэн тохиолдлын тоо нэмэгдсээр байна. 1994-2009 оны хооронд ХДХВ-ийн халдварын нийт 62¹⁵ тохиолдол бүртгэгдсэн ба 2009 онд Улаанбаатар хотод ХДХВ-ийн халдварын 13 тохиолдол бүртгэгдэж, насны ангилалаар авч үзэхэд 15-44 насны хүмүүс байна. ДОХ-ын нийт тохиолдлын 90 хувь буюу 57 нь 2005-2009 оны хооронд бүртгэгдсэн байна. ХДХВ-ийн халдвартай гэж бүртгэгдсэн тохиолдлууд 100 хувь бэлгийн замаар халдвар авсан байна.

Нөхөн үржихүйн асуудал нь судалгаанд хамрагдаж буй “залуучууд” буюу 15-35 насныханд зонхилон хамаарах бөгөөд үүнд гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох, эхийн эндэгдлийг бууруулах, үр хөндөлтийг бууруулах зэрэг эмзэг асуудлууд багтаж байна. Эхийн эндэгдлийн тоо тогтвортой буураагүй байгаа ба энэ нь зарим талаараа төрөх байр, үүнд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж чанар хангалтгүй байгаатай холбогдоно. 2009 оны тоон үзүүлэлтээр эндсэн эхчүүдийн 82 хувийг 20-34 насныхан, 18 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүд эзэлж байв. 2009 оны “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд” судалгаагаар 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн тоо (183.3) 2008 оны үзүүлэлттэй (178.9) харьцуулахад 14.4 нэмэгдсэн байна. Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 20 доош насныхан 6.2 хувь, 20-34 насныхан 70.1 хувь 35-аас дээш насны эмэгтэйчүүд 23.7 хувийг тус тус эзэлж байв.

Хүн амын нас баралтын байдлыг 20-44 насны бүлгийнхэний дунд авч үзэхэд гэмтэл, гадны шалтгаант өвчин тэргүүлэх байрыг эзэлж байна. 2009 оны тайланд гаргасан гадны шалтгаант өвчнийг дотор нь авч үзэхэд 18.8 хувь нь амиа хорлох, 70 хувь нь зам тээврийн болон бусал осол, 11.2 хувь бусдад хорлогдсон шалтгаанаар нас барсан байв. Ер нь эрэгтэйчүүдийн дунд гадны шалтгаант үхлийн хэмжээ эмэгтэйчүүдийнхээс хавьгүй өндөр байгааг дурджээ.

Ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, амьжиргааны түвшин доогуур ядуу хүмүүс, залуучуудад амьдралын гутранги сэтгэл зүй бий болж, чөлөөт цагаа үр бүтээлгүй өнгөрөөх, архи, тамхи бүр мансууруулах бодис хэрэглэх үзэгдэл түгээмэл болон нэмэгдэх хандлагатай болсон байна.

¹⁵ Үндэсний статистикийн хорооны 2010 оны эхний 9 сарын байдлаар гаргасан мэдээллээр ХДХВ-ийн халдвар авсан тохиолдлын тоо 2010 онд 19-өөр нэмэгдэж улсын хэмжээнд нийт 81-т хүрсэн байна.

Залуучуудын дунд төрийн болон олон нийтийн байгууллагын зүгээс олон улсын байгууллага, төслийн санхүүжилтийн тусламжтайгаар чөлөөт цаг өнгөрөөх, эрүүл амьдралын хэв маягт сургах олон үйл ажиллагаа явуулж байгаа боловч энэ нь олныг хамарч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Залуу хүмүүс урлаг спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нийтлэг эрх ашиг байгаа боловч үүнийг дэмжсэн төрийн тодорхой бодлого үгүйлэгдэж байна. Жишээлбэл, судалгааны ярилцлагад хамрагдсан залуусын ярианаас үзэхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх байр савны асуудал дутмаг (бүжиг, наадам), спортын заал талбайн хүртээмж бага, байгаа нь тэднийг нийгмийн идэвхигүй байлгах суурь нөхцөлийг бүрдүүлэх, биеийн тамир спортоор тогтмол хичээллэдэггүйгээс идэвхитэй хөдөлгөөний дутагдалд орох, улмаар энэ нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амьдралын буруу хэв маягт автах (баар, цэнгээнд цагаа үрэх, компьютер тоглоомны донтон болох) зэрэг байдалд хүргэдгийг хэлж байлаа.

Эндээс үзэхэд залуучуудад тулгамдаж буй эрүүл мэндийн асуудалд нөхөн үржихүйн болон БЗХӨ-өөс сэргийлэх мэдлэг боловсрол олгох явдал, эрүүл амьдрах хэв ёс, зан үйлд сургах (архи тамхи, мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх), тэдний сэтгэлзүйн дэмжлэг олгох, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх байр савны асуудлыг шийдэх зэрэг нь орж байна.

ШИГТГЭЭ

Залуучуудаа, чөлөөт цагаараа юу хийж байна? Сэдэвт хэлэлцүүлэгт залуус дараахи байдлаар хариулт өгч байна./<http://biznetwork.mn/topic/show/2177/1/>

Ж. Лувсандорж

Монгол орныг ЗАЛУУСЫН ОРОН гэдэг. Нийслэл Улаанбаатар хотын хүн амын 60% нь залуучууд хэдий ч тэдэнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ТӨВ нэг ч байхгүй байгаа нь харамсалтай. Залуучууд нэгнээсээ суралцаж, хамтдаа хөгжих боломжийг бий болгосон эерэг таатай орчин үнэхээр их үгүйлэгдэж байна. Хүний хөгжил, тэр дундаа залуусын хөгжилд хөрөнгө оруулалт хийх нийгмийн хэрэгцээ шаардлага асар их байна.

Д.Дашбаяр

Чөлөөт цагаараа миний хувьд нойроо ханатал унтчихаад хувцасаа угааж, гэр орноо дангинатал цэвэрлэж кино үздэгдээ. Одоо сүүлийн үед энэ бизнэс төрлөөр дэмий сэлгүүцэж явдаг болсон. Аа завтай байгаад маргааш нь ажилгүй бол найзуудтайгаа нийлж шоудах пиво ууж караокэд орох дуртай. Тэгжил чөлөөт цагаа өнгөрөөдөг дөө. Бусдад үлгэр болчихоор юм бичсэнгүй дээ. Өөрийн тухай л тийм гэдгээ бичсэн шүү уучлаарай.

5. Залуучуудын нийгмийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх

Залуучуудын нийгэмд эзлэх байр суурийг бий болгоход тэдний нийгмийн харилцаан дахь оролцоо, үүргийг нэмэгдүүлэх явдал чухал юм.

Залуучуудын нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд залуус ашиг сонирхлын дагуу нийгмийн доторхи бүлэг эвсэлд сайн дураар нэгдэн орох үйл явцыг дэмжих, тэдний сурч боловсрох, бусдын соёлоос суралцах гадаад үйл ажиллагааг дэмжих, залуучуудын байгууллагуудын нийгэмд тустай сайн дурын үйл ажиллагааг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах, төлөөллийн байгууллагын дуу хоолой байр суурь төрийн бодлого шийдвэрт тусдаг тодорхой ойлгомжтой механизм бүрдэх ёстой билээ.

Манай улсад залуучуудын сайн дурын маш олон ТББ, эвсэл холбоод байгаа бөгөөд үүнд залуус сайн дураар нэгдэн орох бүрэн боломж бололцоотой байна. Гэвч залуучуудын сайн дурын байгууллагуудын дотоод ил тод байдал хангалтгүй, хөрөнгө санхүүжилтийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах чадамж боломж бага байгаа зэрэг нь эдгээр байгууллагууд залуучуудад чиглэсэн нийтлэг асуудлаар бус явцуу эрх ашгийн хүрээнд үйл ажиллагаа явуулах шалтгаан нөхцөл болдог.

Намуудын дэргэдэх залуучуудын байгууллага, ярилцлагад оролцсон зарим залуусын үзэж байгаагаар Монголын залуучуудын холбоо, Монголын оюутны холбоо зэрэг байгууллага нь залуучуудын нийтлэг эрх ашгийг хамгаалахаас илүүтэй улс төрийн зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа явуулдаг гэж үзжээ. Энэ нь залуучуудын төлөөллийн байгууллагад залуусын итгэх итгэлийг алдуулж улмаар нийгмийн оролцоог багасгах нэг хүчин зүйл болж байна.

Дээрхи нөлөө бүхий гэж хэлж болох залуучуудын байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудад тулгамдаж буй нийтлэг хүндрэл бэрхшээлийг шийдэхээс илүүтэй шоу, цэнгүүний арга хэмжээ голлож байгааг цаашид анхаарах шаардлагатай асуудал гэж үзэж байна.

Засгийн газраас гаргасан “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-г залуучуудын нийгмийн оролцоог дэмжих зорилт багтсан боловч энэ нь нэлээд тунхаглалын шинжтэй, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилт тодорхойгүй байгаа зэргээс хамаарч ирүүлсэн тайлангийн дүгнэлтэнд дурдсан хэрэгжилт тодорхой бус, хамрах хүрээ бага байсныг харуулдаг.

Төрөөс гарч буй бодлого шийдвэрт залуучуудын эрх ашгийг тодорхойлон тусгах амьд механизм байхгүй нь бодлого шийдвэр уялдаа холбоо багатай, салангид шинжтэй, ойлгомж муутай гарах, залуучуудын бодит асуудлыг шийдвэрлэхэд тусдаггүй, өнгөн хэлбэртэй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

3. ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮД, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

Залуучуудад чиглэсэн нийгмийн бодлого нь тэдэнд боловсрол, мэргэжлийг эзэмшүүлэх, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах болон чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, залуучуудын нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, манлайллыг бий болгох зэрэгт чиглэн хэрэгждэг.

Манай улсад залуучуудад чиглэсэн нийгмийн бодлогыг зангидан хариуцсан төрийн бүтэц, институци байхгүй байгаа нь уг нийгмийн бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй бус байх, хэрэгжилт тодорхойгүй байхад нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш залуучуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөгжлийг дэмжих чиглэлээр хэд хэдэн бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Үүнд, Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр, “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Залуучуудын хөгжлийн асуудлаар НҮБ-тай хамтран ажиллах ойлголцлын санамж бичиг, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, “Зөгийн үүр” хөтөлбөр зэргийг дурьдаж болно.

ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮД

- **Мянганы хөгжлийн зорилт**

2000 онд НҮБ-ын оролцоотойгоор зохион байгуулсан Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаас 21 дүгээр зуунд дэлхийн улс орнууд 2015 он хүртэл ядуурлыг бууруулах, нийгмийн хөгжлийн асуудлыг тодорхой зорилго зорилтын дагуу хамтран шийдвэрлэхээр “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг баталсан бөгөөд эдгээр зорилтууд дотор залуучуудад чиглэсэн буюу тэдэнд хамаарах хэд хэдэн арга хэмжээ багтсан юм.

Тухайлбал, ядуурал өлсгөлөнг бууруулах, бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших, хүүхэд, эхчүүдийн эндэгдлийг бууруулах, бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ-той тэмцэх зэрэг зорилтууд нь залуучуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд мөн чиглэж байгаа болно.

УИХ-ын 2008 оны 13-р тогтоолоор 9 зорилго, 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэйгээр Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг батлан хэрэгжүүлж байна. Монгол Улс 2010 онд хүртэл Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтээр Үндэсний гурван удаагийн илтгэлээ гаргаад байгаа бөгөөд Үндэсний гуравдах илтгэлээр МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд дараахь тулгамдаж буй (залуучуудад мөн адил хамаарах) арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар дурджээ. Үүнд:

- Бүс нутаг хоорондын хөгжлийн ялгаатай байдлыг арилгах (ядуурал, ажилгүйдэл);
- Сургууль завсардалт дорвитой буураагүй, сурах бичгийн хангамж дутмаг байгаа, хөдөө орон нутгийн суурь боловсрол эзэмших нөхцөл хангалтгүй байгаад боловсролын салбарын бодлого баригчид нухацтай хандах;

- Иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх;
 - ХДХВ/ДОХ-д өртөх эрсдэл өндөртэй нийгмийн бүлэгтэй (залуучууд) ажиллах;
 - Нийгмийн зорилтот бүлэг, мэдээллийн бааз, хяналт шинжилгээг сайжруулах шаардлагатай байгаа;
- зэрэг багтжээ.

• Үндэсний хөгжлийн цогц бодлого

2008 онд батлагдсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого нь монгол хүний хөгжил, манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд авах арга хэмжээ, алсын харааг 2008-2021 он хүртэл тогтоон, дунд хугацааны болон зорилтот хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд тусгах бодлогын зорилтуудыг тодорхойлсон хөгжлийн чухал баримт бичиг билээ. Тус бодлогын баримт бичиг нь залуучуудын хөгжлийн асуудлыг тусгайлан авч үзээгүй бөгөөд хөгжлийн зургаан тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байдаг. Эдгээр чиглэлүүдийн эхнийх нь болох Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж, монгол хүнийг хөгжүүлэх зорилтын чиглэлийн хүрээнд залуучуудын хөгжлийн асуудлууд тусгагдсан байна.

- Тухайлбал тус баримтын 4.3-ын “Гэр бүлийн хөгжил, хүн амзүйн бодлого”-ын Стратегийн зорилт 2-т “...хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх, хамгаалах, зуучлах нийгмийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх; өсвөр үе, залуучуудад ардчилсан, эх оронч үзэл, үндэсний уламжлал, хэл соёл, зан заншлыг төлөвшүүлэх” тухай заажээ.
- 4.4-ын “Боловсролын хөгжлийн бодлого”-ын Стратегийн зорилт 2-т “...тэргүүлэх мэргэжилтнийг төрийн бодлогоор дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлж, авьяас чадварыг хөхиүлэн дэмжих зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, түүнд зориулсан хөрөнгийг нэмэгдүүлж, оновчтой санхүүжүүлэх; уул уурхай, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр эхний ээлжинд 1000 залууг тусгай сонгон шалгаруулалтаар сонгож, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр энэ чиглэлээр хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудад сургах сургалтын зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлэх” тухай орсон байна.
- 4.7-ын “Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого”-ын стратегийн зорилт 1-т “Залуу судлаачдыг дэмжих” зорилтот хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийн болон санхүүжилтийн бодлого боловсруулж, хэрэгжилтэд шинэчлэл хийх” гэж заасан.
- 4.8-ын “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого”-ын стратегийн зорилт 2-т “гадаадад ажиллаж, амьдарч байгаа, өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, өөрийн мэргэшсэн чиглэлээрээ

ажлын байр бий болгох санал санаачилгыг хөхиүлэн дэмжих” тухай заалт оржээ.

• ЗГ-ын мөрийн хөтөлбөр (2008-2012)

Монгол Улсын УИХ-ын 2008 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүн ам, нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах” нэгдүгээр зорилтод залуучуудын нийгмийн асуудалтай холбоотой хэд хэдэн арга хэмжээг авахаар тусгагдсан байна. Үүнд:

- 1.1.7. Хүн ам, ялангуяа өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг боловсронгуй болгож, хөдөөгийн хүн амд үйлчлэх явуулын эмнэлгийн тогтолцоог бүрдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.20. БЗДХ, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлж, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын тархалтыг өнөөгийн түвшинд тогтоон барина.
- 1.2.18. Оюутны сурлагын амжилтыг харгалзан сургалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, тэтгэлэг олгох, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.19. Хичээлийн болон дотуур байр, номын сан, биеийн тамирын заал барих, өргөтгөх, сургуулийг компьютержүүлэх, интернэтэд холбох зэргээр чанартай боловсролын орчин бүрдүүлэхэд өөрчлөлт гаргана.
- 1.2.29. Зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангахуйц судалгаа, боловсруулалтын ажлын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог өргөтгөхийн хамт, эрдэм шинжилгээний ажилтан, залуу эрдэмтдийг дэмжинэ.
- 1.3.1. Ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн идэвх, санаачилгыг дэмжин бизнес эрхлэх орчныг бүрдүүлэх, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулна.
- 1.3.2. Хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог иж бүрнээр хөгжүүлж, ажилтан, ажилчдыг зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сургаж бэлтгэх, ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагажуулах тогтолцоог бий болгоно.
- 1.3.4. Хүн амын насны бүтцэд гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан хүн амын бүлгүүдийн зохистой, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.2. Нийгмийн хамгааллын бодлого нь нийт иргэдийн эрх ашигт нийцсэн байх бөгөөд тусгайлсан хөтөлбөр, арга хэмжээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх арга зүй, зохион байгуулалтыг сайжруулна.
- 1.4.4. Шинээр гэр бүл бологсод, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно.

- 1.4.15. Хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын дадал олгох, аливаа хорт, муу зуршлаас ангид байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгох чиглэлээр гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 1.5.1. Гэр бүл бат бэх байх, уламжлалт ёс заншлыг хүндлэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, авъяасаа хөгжүүлэх, сурч боловсрох эрмэлзэлтэй, бүтээлч, хариуцлагатай, хувь заяандаа эзэн болж төлөвших, хүүхэд аюулгүй орчинд эрүүл өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.5.3. Нийгмийн анхдагч нэгж болсон гэр бүлийн харилцааны үнэт зүйл, ёс зүйг төлөвшүүлэх талаар соён гэгээрүүлж, зөвлөн туслах үйлчилгээний шинэ төрлүүдийг хөгжүүлнэ.

Тус хөтөлбөрт залуучуудад чиглэсэн хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан боловч авах арга хэмжээ, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо тодорхойгүй, нэлээд тунхаглалын шинжтэй зүйлс багтсан байгаа нь харагдана.

• Хүний хөгжил сан

Стратегийн ач холбогдол бүхий томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх зорилт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан. Тус зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр баталсан 84 дүгээр тогтоолоор 2010-2012 онд Монгол Улсын иргэн бүрт 1.5 сая төгрөгийг тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны төлбөрийн эрх болон бэлэн мөнгө гэсэн хэлбэрээр олгохоор тогтсон.

Үүнд залуучуудын боловсрол, нийгмийн хамгааллыг дэмжих, амьжиргааг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн бодлогод хамаарах дараахь арга хэмжээнүүд туссан байна.

- Тэтгэврийн, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийн (үүнд албан бус секторт ажиллаж буй залуучууд багтана) шимтгэлийг тэтгэврийн санд нөхөн төлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Орон сууц худалдан авах урьдчилгаа, зээл болон зээлийн хүүг төлөхөд зориулан орон сууцны төлбөрийн эрх олгох;
- их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдын сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, сургуулийн дүрэмт хувцасны төлбөр, ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд хурдавчилсан сургалтаар мэргэжил эзэмшүүлэхэд зориулан төлбөрийн эрх олгох;
- Иргэдийг халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор шинээр нэвтрүүлсэн вакцин, нарийн мэргэжлийн болон явуулын амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамрагдах төлбөрийн эрх олгох;

Гэвч эдгээр бодлого шийдвэр нь төрөөс хэрэгжүүлж буй мөнгө санхүүгийн бодлоготой уялдаа холбоо муутай, нийгмийн тодорхой бүлэгт чиглээгүй, хэт

хавтгайруулсан, популист шинж чанартай, тогтвортой бус бодлогууд гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

- **Монгол Улсын Засгийн газраас баталсан “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” 2007-2015 он.**

Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийг 1998-2005 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд залуучуудын эрүүл мэндийг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий мэдлэг, боловсрол эзэмшүүлэх, мэдээллийг цаг үеэсээ хоцролгүй хүртэх боломж нөхцлийг нэмэгдүүлэх зэрэг арав гаруй багц үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Гэвч хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан, МУ-ын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого, Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр зэрэг залуучуудын хөгжлийн асуудлыг хөндсөн бодлого, хөтөлбөр шинээр батлагдсантай холбогдуулан тус хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах шаардлага гарсны дагуу Монгол Улсын Засгийн газраас “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 11 сарын 282 дугаар тогтоолоор батлагдсан “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” нь залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, эрх ашгаа хамгаалах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх ээлтэй орчинг бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, тэдний улс оныхоо хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгыг тавьсан бөгөөд 2007-2015 он хүртэл 3 үе шаттайгаар 4 үндсэн чиглэлд 24 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Энэхүү хөтөлбөрийн дээр дурьдсан 24 зорилт нь залуучуудад тулгамдаж буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээнүүд цогц байдлаар тусгагдсан боловч хэрэгжүүлэх арга зам, механизм тодорхойгүй буюу хэн санхүүжүүлж, хэрхэн зохион байгуулж хэрэгжүүлэх нь ойлгомжгүй, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд нь тодорхой гараагүй зэрэг нь тус хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитойгоор үнэлж дүгнэх боломжгүй болгож байна.

Тус судалгааны ажлын хүрээнд “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 2008, 2009 оны хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцлаа.

НХХЯ-ны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газраас гаргасан тайлангийн үнэлгээгээр тус хөтөлбөрийн 2009 оны хэрэгжилт 40,8 хувьтай, явцын хэрэгжилт 17,2 хувьтай байна. Хөтөлбөрийн 1-р үе шат болох 2007-2008 оны хэрэгжилт 11,6 хувийн биелэлттэй гэж үзсэн байна.

Судлаач миний бие тайлангийн материалтай танилцаж НХХЯ-наас зарчмын зөрүүтэй дараахь санал дүгнэлтийг тус хөтөлбөрт өгч байна.

- Хөтөлбөрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд зөвхөн сургалт, сурталчилгаанд чиглэсэн арга хэмжээнүүд багтсан байна. Эдгээр арга хэмжээнд өсвөр үе, залуучуудыг хамруулсан хүрээ бага, үр дүн багатай болсон гэж үзэж болохоор байна. Жишээлбэл, хөтөлбөрийн зорилт 5-д тусгагдсан залуучуудыг орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Шинэ байр” ТВ шоунд 5 байгууллагын хосуудыг оролцуулан тэргүүн байр эзэлсэн хосод 1 өрөө байр олгож шагнасан явдлыг тайланд тусган, хэрэгжилтийг 10 хувьтай хэмээн үзсэн байна. Гэтэл энэ нь залуучуудад нийтлэг байдлаар чиглэсэн орон сууцжуулах төрийн бодлого бус, хамрах хүрээ багатай тул хэрэгжилтийг 10 хувьтай гэж үзэх үндэсгүй юм. Тус тайланд дээрхтэй ижил байдлаар дүгнэсэн арга хэмжээнүүд нэлээд тохиолдож байна.
- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2008 онд 26,7 сая, 2009 онд 20,0 сая төгрөгийг улсын төсвөөс төсөвлөсөн нь хөтөлбөрт тусгагдсан олон арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн боломж нөхцөл хязгаарлагдмал байгаа болон үр дүн багатай хэрэгжих нэг нөхцөл шалтгаан болохыг харуулна.
- НХХЯ-наас гаргасан тайлангийн үнэлгээгээр ТББ, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо, идэвхи санаачлага бага, хамтын ажиллагаа тааруу байгаа нь хэрэгжилт муу байх нэг үндэс болсон талаар дурьджээ. Гэвч тус хөтөлбөрт олон нийтийн байгууллагуудын оролцоо ил тод, ойлгомжтой бус байгаа тул асуудлыг тодорхой эзэн биегүй субъектэд хамаатуулан дүгнэж байгаа нь өрөөсгөл юм.

• “Зөгийн үүр” хөтөлбөр

Өнөөдөр албан бус тоогоор 200 мянга орчим Монгол Улсын иргэд хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч байгаа нь манай улсын нийт ажиллах хүчний 9.3-18.6 хувийг эзэлж байгаа ба эдгээрийн дийлэнх олонх нь залуу насны хүмүүс байна¹⁶.

Монгол Улс ойрын жилүүдэд эдийн засаг, нийгмийн салбарт бүтээн байгуулалтын томоохон хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж эхэлж буйтай холбоотойгоор 2010-2015 онд хөдөлмөрийн зах зээл дээр нийт 40000 гаруй ажлын байр шинээр бий болохоос 6000 гаруй инженер техникийн ажилтан шаардлагатай байгаа ба өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт шинээр ажиллах хүчний эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэх төлөвтэй байгаа юм байна.

Монгол Улсын Засгийн газар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн боловсон хүчнийг бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх ажлыг зохион байгуулахад онцгой анхааран ажиллаж байгаа хэдий ч тухайн үйлдвэрлэл дээр ажиллах, шаардлага хангахуйц нарийн мэргэжлийн, өндөр ур чадвартай хүний нөөц хангалттай бус, бэлтгэгдэх боломж хомс байгаа нь судлагджээ.

Иймээс Засгийн газар хилийн чанадад сурч, ажиллаж амьдарч байгаа өндөр боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэд, залуучуудыг эх орны

¹⁶ МУ-ын Засгийн газраас баталсан “Зөгийн үүр” хөтөлбөрийн танилцуулгаас

хөгжил, бүтээн байгуулалтад татан оролцуулах зорилгоор 2010 оны 7-р сард “Зөгийн үүр” хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

Залуучуудын нийгмийн бодлогуудыг зангидан хэрэгжүүлэгч төрийн бүтэц манай улсад байхгүй байна. Гэвч боловсрол, соёл, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд гэсэн чиглэлүүдээр залуучуудтай холбоотой нийгмийн асуудлыг хариуцаж үйл ажиллагаа явуулдаг дараахь төрийн институциуд ажиллаж байна. Үүнд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
- Эрүүл мэндийн яам
- ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар
- Хүний хөгжил сан
- Орон нутаг дахь нийгмийн бодлогын газар, хэлтэсүүд

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын хэрэгжилтийг нийтлэг удирдамжаар хангах үндсэн үүргийг хүлээж боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, нийтлэг зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжүүд байна. Тухайлбал тус яамны Мэргэжлийн боловсролын газар, Бага дунд боловсролын газар, Соёл урлагийн газар, Шинжлэх ухаан технологийн газар зэрэг бүтцийн нэгжүүд нь дээрхи чиг үүргийг хэрэгжүүлэхээр ажилладаг.

Тус яамны харьяа Сургалтын төрийн сан, Шинжлэх ухаан технологийн сан, Соёл урлаг хөгжүүлэх сан зэрэг нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан тусгай хуулиар зохицуулагдан боловсрол, соёл, сургалтын үйл ажиллагааг дэмжсэн санхүүжилт хийж байна.

2010 оны байдлаар Улаанбаатар хотод их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуульд сурч буй 130 мянга гаруй оюутнаас 80 мянган оюутан тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих эрхийг авсан байгаа бөгөөд Монголын оюутны холбооны зүгээс цаашид шаардлагатай байгаа 16 мянган оюутныг уг арга хэмжээнд хамруулах арга хэмжээг авах саналтай байна. Гэвч оюутан залуусыг тээврийн хэрэгслээр үнэгүй зорчуулах энэхүү бодлого нь залуучуудын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэж байгаа мэт боловч тээврийн байгууллагуудын нөхөн төлбөр, санхүүжилтийн тогтолцоо ил тод бус, зах зээлийн мөн чанар

бодлоготой уялдаагүй явагдаж байгааг анхаарч тогтолцооны хувьд үндсээр нь шинэчлэх шаардлагатай байгааг харуулна.

Сургалтын төрийн сан

Сургалтын төрийн сан их, дээд сургууль коллежид суралцагчдад (залуучуудад) сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ ЗГ-ын тогтоолуудаар батлагдсан журмуудын дагуу хагас болон бүтэн өнчин, амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагчид, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, шагналын хэлбэрээр элсэгчид, төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцагч, түүнчлэн өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчидтай гурвалсан гэрээ байгуулан сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгохын зэрэгцээ зээлийг буцаан төлүүлэх, санхүүжилтийн төсөв, тооцоо хийх, тайлагнах, хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна.

2001 оны байдлаар сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг нийт 11189 оюутан 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авч байсан бол 2009 оны байдлаар 9853 оюутан 5766.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авчээ. Харин амьдралын түвшингээс доогуур орлоготой иргэдэд олгох буцалтгүй тусламжийг 2001 оны байдлаар 5281 суралцагч 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр авсан бол 2009 онд 14379 оюутан 5.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авчээ

Төрийн албан хаагчийн гэр бүлийн 1 оюутны төлбөрийг төрөөс даан санхүүжүүлэх тухай Засгийн газрын 201–р тогтоолын дагуу 2001 онд 12262 оюутан 3,19 тэрбум төгрөгийн санхүүжилт авч байсан бол 2009 онд 16380 оюутаны сургалтын төлбөрт 7.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Өндөр хөгжилтэй оронд магистр, докторантурт суралцагчдын тоо 2001 онд 279 байж 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авч байсан бол 2009 онд 131 суралцагч 2.9 тэрбум төгрөгийн зээл авчээ.

2009 оны байдлаар нийт 40743 оюутан суралцагчид 21.4 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн санхүүжилт авсан байна. Энэ нь манай улсын их, дээд сургуулийн нийт суралцагчдын 25% -ийг эзэлж байна гэсэн үг. Хэдий сурлагын голч дүн (2.8-иас дээш байх), нийгмийн байдал (хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу, малчны болон төрийн албан хаагчийн нэг хүүхэд), Засгийн газраас тэргүүлэх чиглэл болгосон мэргэжлийг сонгосон байдал (инженер, байгалийн ухаан, анагаах ухаан) зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан тухайн оюутанд зээл олгож байгаа нь сайшаалтай боловч зээл эргэн төлөх асуудал биелэгддэггүй, хүндрэлтэй асуудлын нэг болсоор байна. Энэ нь зээлийг эргэн төлөх шалгуур үзүүлэлт нарийн тодорхойлогдоогүй, зээл авсан суралцагчдад хариуцлага үүсгэх тогтолцоо бий болоогүй, зарим үед улс төрийн шинжтэй популист бодлогын үр уршгаар сургалтын төлбөр хүчингүй болгох төрийн бодлого хэрэгжиж нийгэмд бэлэнчилсэн хүлээлт бий болгодог зэрэгтэй холбоотой.

Засгийн газрын 2004 оны 21-р тогтоолоор оршин суугаа газраасаа 500 километр болон түүнээс хол байршилтай их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өвлийн амралтаараа орон нутагтаа очиж амрахад явсан баримтыг нь үндэслэн аймгийн төв хүртэлх тээврийн нэг талын зардлыг Сургалтын төрийн сангаар

дамжуулан олгож байх шийдвэр гарсан. Энэхүү бодлогын үр дүнд алслагдмал орон нутагт амьдардаг оюутнуудын нийгэм, санхүүгийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж байгаа бөгөөд 2009 онд 10538 оюутанд 383.9 сая төгрөгийн зардлыг төрөөс даасан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Сүүлийн жилүүдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилчин бэлтгэх асуудлыг төрөөс дэмжиж, мэргэжлийн боловсролын сургуульд суралцах залуучуудын тоог нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байна. Мэргэжлийн сургуульд эхлэн суралцагчдын сургалтын зардлыг төрөөс хариуцаж ирсэн боловч эдгээр сургуульд зорьж ирэх сонирхол төдийлэн өндөр байгаагүй буюу ерөнхий боловсролын сургууль төгсгөгчдөөс элсүүлэх хяналтын тоо биелж байсангүй. Харин 2008 оны эхнээс мэргэжлийн сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох болсноор элсэлт нэмэгдэж эхэлсэн байна. Эдгээр сургуульд мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол эзэмшүүлэх ангид суралцагчдын тоо 2008 онд 37.9 мянгад, эхлэн суралцагчдын тоо 19.2 мянгад хүрчээ¹⁷ (2008 онд Засгийн газраас нэг суралцагчид ногдох зардлыг 465-495 мянган, тэтгэлэгийг сарын 45 мянга, жилд 450 мянган төгрөг төгрөгөөр баталсан). Үүний үр дүнд нийт 27 мянган суудалтай эдгээр сургуулийн ихэнх нь 2 ээлжинд шилжлээ. Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг БСШУЯ-ны Мэргэжлийн боловсролын газар хэрэгжүүлж байна.

АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацийн “Техник, мэргэжлийн боловсрол сургалт” хөтөлбөр нь манай улсад хэрэгжиж буй мэргэжлийн боловсролын салбарыг хөгжүүлэх, ажилгүй болон мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн томоохон төсөл юм. Нийт 25.5 сая ам долларын төсөвтэйгээр 2008 оны 10-р сараас эхлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2009 оны 9 сард АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацийн удирдах зөвлөлийн хурлаар тус төслийг өргөтгөх шийдвэр гарч 22.1 сая ам доллар нэмсэнээр нийт төсөв нь 47.6 сая ам доллар болсон.

Шинжлэх ухаан, технологийн сан

Шинжлэх ухаан, технологийн салбарт эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгаа туршилт үйлдвэрлэлийн нэгдэл, их сургуулиудыг багтаасан төрийн өмчийн 50 эрдэм шинжилгээний байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 2500 орчим эрдэм шинжилгээ, инженер техникийн ажилтнууд эдгээр байгуулагад ажиллаж байна. Эдгээр ажилтануудын 40 орчим хувь нь 35 хүртэлх насны залуу эрдэмтэн, судлаачид эзэлж байна. Залуу судлаачдын хувьд судалгаа, эрдмийн ажил хийх хугацаанд грант тэтгэлэгийн төрийн үйлчилгээ, санхүүжилт байхгүй, судалгаа, шинжилгээ, туршилтын зардал мөнгө дутагдалтай байдаг зэрэг нь тулгамдаж буй асуудал юм.

¹⁷ www.mecs.gov.mn Мэргэжлийн боловсрол сургалт

Шинжлэх ухаан, технологийн сан нь шинжлэх ухаан, технологийн төсөл, онолын суурь судалгаа, грант төсөл, инновацийн төсөл гэсэн судалгааны ажлыг дэмжих, түүнд шаардагдах санхүүжилтийг хэрэгжүүлдэг. Гэвч сүүлийн жилүүдэд тус сан үйл ажиллагааныхаа чиглэлийг өргөтгөн, залуучуудад чиглэсэн хэд хэдэн үйл ажиллагааг эхлүүлээд байна. 2004 оноос эхлэн төрийн ба төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудад ажиллаж буй 35 хүртэлх насны Монгол Улсын иргэнд судалгаа, шинжилгээний ажил явуулахад нь туслах зорилготой “Залуу судлаачдыг дэмжих грант”-ыг (тус бүр 2 сая төгрөг) нийт 56 залуу судлаачдад олгоод байгаа ба эдгээрээс шилдэг нэг залуу эрдэмтэнд жил бүр Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналыг хүртээдэг. Энэ залуу судлаачдыг судалгаа шинжилгээний ажлыг хөхиүлэн дэмжих чухал арга хэмжээ болж байна. 2010 оноос эхлэн докторын зэрэг хамгаалсан залуу судлаачдад тэдний судалгааны ажил бүтээлч сэтгэлгээг дэмжих зорилгоор тодорхой шалгуурын дагуу 10 сая төгрөгийн “Пост докторын грант”-ыг 6 залуу эрдэмтэнд олгосон байна.

Гэвч судалгаа шинжилгээ хийж буй залуучуудад нийтлэг байдлаар хүрэх, тэдний нийгмийн асуудал, чанартай судалгаа шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх тогтолцоог бий болгох нь дутагдалтай байгааг тэмдэглүүштэй.

Соёл, урлаг хөгжүүлэх сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар үйл ажиллагаа явуулж буй сангуудыг нэг нь Соёл, урлагийг дэмжих сан бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлд соёлын өвийг хамгаалах, соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулах, соёлын гадаад харилцааг хөгжүүлэх зардлыг санхүүжүүлэхээр заагдсан ба тухайлан залуучуудад чиглэсэн арга хэмжээ, бодлогын арга хэмжээнүүд тусгагдаагүй байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

Тус яаман дээр өсвөр үе, залуучуудыг хөгжүүлэх чиглэлээр “Монгол Улсын хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” үндэсний хөтөлбөр, “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр зэрэг хэд хэдэн бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаж байна. Гэвч эдгээр бодлогын баримт бичгүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээ нь уялдаа бага, хүртээмжгүй байгаа, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв санхүүгийн дутагдал, холбогдох суурь судалгааг тогтмол хийх боломж хязгаарлагдмал зэргээс шалтгаалж үр дүн багатай гэж үзэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хүн амын тэр дундаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж байна.

Тус сан нь хувиараа болон өрхийн аж ахуй, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсэгчдийг сургалтанд хамруулах, зээл олгох, ажил олгогчийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг үйл ажиллагааг санжүүлж байна.

Сангаас сүүлийн жилүүдэд залуучууд, оюутан, сурагчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хөдөлмөрийн биржийг ажиллуулах, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг их дээд сургууль дээр байгуулахаар төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа боловч хөдөлмөрийн эрэлт бага, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой дэмжсэн төрийн тодорхой бодлого дутагдалтай, эрхзүйн ойлгомжтой орчин бүрдээгүй, зөвхөн халамжийн шинж чанартайгаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого барьж байгаа нь энэхүү арга хэмжээг үр дүнтэй болгоход саад учруулж байна.

Эрүүл мэндийн яам

Тус яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдрах хэв маяг, зан үйлийг бий болгох, нөхөн үржихүй, БЗХӨ болон ДОХ-ын асуудлыг хариуцдаг. Энэ чиглэлээр НҮБ-ын Хүн амын сан болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын залуучуудын эрүүл мэндийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүд хэрэгждэг нь энэ чиглэлийн бодлогын арга хэмжээ нь үр дүнтэй байгаа үндэс гэж үзэж болно.

Манай улсад зөвхөн залуучууд гэлтгүй нийгмийн бусад бүлгүүдэд чиглэсэн, эрүүл мэндийн даатгалын болон эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй, чанартай, тогтвортой үйлчилгээний тогтолцоо бүрэлдээгүй байна.

Эрүүл мэндийг дэмжих сан

Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь улсын төсвийн хөрөнгө, гадаад дотоодын хандив тусламж зэрэг санхүүгийн эх үүсвэр болон тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэнэ.

Сан нь тамхи, архины хяналтыг бий болгох, эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хийдэг. Сүүлийн жилүүдэд манай улсад залуучуудын дунд архидалт тамхидалт нэмэгдсэн, бүр мансууруулах бодис хэрэглэх явдал өссөн, залуучуудын эрүүл бус амьдралын хэв маяг бий болсоны эсрэг сургалт, сурталчилгаа хийх, тэдний мэдлэг мэдээллийг дээшлүүлэх арга хэмжээг тус сангаас голлон авч хэрэгжүүлсэн байна.

ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо

2010 оны 9 сар хүртэлхи байдлаар Монгол Улсад ДОХ-ын халдвар авсан тохиолдлын тоо 81-д хүрсэн ба үүнд өртөгсдийн дийлэнх олонхи нь 35 хүртэл насны

залуучууд байгаа нь анхаарал татах асуудал болжээ. Иймд залуучуудыг ДОХ-оос сэргийлэх, бэлгийн замын болон нөхөн үржихүйн зөв зохистой мэдлэг мэдээллийг түгээх арга хэмжээг хэрэгжүүлэх нь уг өвчнөөс сэргийлэх, улмаар хязгаарлах нэг хүчин зүйл болдог.

1992 онд ДОХ өвчинтэй тэмцэх Үндэсний хороог Монгол Улсын Ерөнхий сайдын орлогч, засаг захиргааны сайдаар ахлуулан байгуулсан боловч 1996 онд Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын эрхлэх ажлын хүрээнд байхаар өөрчилсөн. 2006 онд Шадар сайдын удирдлага дор ХДХВ/ДОХ-ын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороог дахин байгуулсан.

Тус Үндэсний хороо нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаархи хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хяналт тавих, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаар төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг тусалцаа үзүүлэх нь зорилготой ажиллаж байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Гадаадад сурч боловсорч, ажиллаж буй өндөр боловсрол чадвар бүхий Монгол улсын иргэд тэр дундаа залуучуудыг манай улсын хөгжлийн үйл явцад татан оролцуулах зорилготой “Зөгийн үүр” хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаанд түшиглэн Засгийн газрын хэрэг эрхлэх газар хэрэгжилтийг зохион байгуулах гэж байна.

“Зөгийн үүр” хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд өндөр боловсрол эзэмшсэн залуучуудын нарийвчилсан тоо бүртгэлийг гаргах ажлыг хийхээр төлөвлөжээ. Үүний дараагаар стратегийн чухал салбаруудад залуусыг эх орондоо ирж ажиллах боломж нөхцөлийг нь хангах, хөдөлмөрийн зах зээлд онц шаардлагатай ажлын байранд ирж ажиллавал үзүүлэх цалин хөлс, урамшууллын тогтолцоо бий болгох, тэдний өндөр боловсрол мэдлэгийг ашиглах бусад арга хэлбэрийг ашиглах зэрэг арга хэмжээнүүд тусгагдсан байна.

Хүний хөгжил сан

Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу уг сангийн хөрөнгийн ерөнхий удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам хэрэгжүүлж байна

“Хүний хөгжил сангийн тухай” хууль батлагдсантай холбоотойгоор “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай” болон “Эх, хүүхдэд, тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулиуд 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчингүй болсны улмаас шинээр төрсөн хүүхдийн тэтгэмж, шинээр гэрлэгсдэд төрөөс нэг удаа олгох мөнгөн тусламж (Залуу гэр бүлд олгох 500000 төгрөг), шинэ төрсөн хүүхдэд төрөөс нэг удаа олгох мөнгөн тусламж, “Монгол Улсын хөгжүүлэх сангийн тухай” хуулийн дагуу олгож байсан хүүхдийн мөнгө тус тус олгогдохгүй болсон юм.

Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэн тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр, орон сууц худалдаж авсны төлбөр, бэлэн мөнгө, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөр гэсэн хэлбэрүүдээс сонгон хишиг, хувь хүртэхээр тогтсон бөгөөд үүнд оюутан залууст хамгийн хамаатай зүйл нь тэдний сургалтын төлбөрийн 500 мянган төгрөгийг 2011, 2012 онуудад төрөөс даах бодлого юм. Тогтвортой орлогын эх үүсвэр байхгүй оюутан залуусын хувьд энэ тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх чухал арга хэмжээ мэт харагдавч хэт хавтгайруулсан, улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаагүй, тогтвортой бус шинж чанартай, зарим судлаач олон нийтийн бүлгийн үзсэнээр нийгэмд бэлэнчлэх үзлийг бий болгосон, улс төрийн “шоу” бодлого болсон гэж үзэж болно.

Орон нутаг дахь нийгмийн бодлогын газар, хэлтэсүүд

Аймаг, нийслэл, орон нутагт боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, соёл урлаг, хүүхэд, өсвөр үеийн гэсэн залуучуудын нийгмийн бодлогыг давхар хариуцсан газар, хэлтэсүүд ажиллаж байна.

Хэдий залуучуудын асуудал хариуцсан бүтэц, ажилтнууд орон нутгийн түвшинд байгаа боловч бодлого зангидан хэрэгждэггүй, ажилтнуудын мэдлэг чадвар дутмаг, авилга хүнд суртал их байдаг болон орон нутгийн ажил үйлчилгээ явуулах эрх мэдэл бага, санхүүжилт хязгаарлагдмал байдаг зэрэг нөхцөл байдлаас улбаалж залуучуудад чиглэсэн бодлого зөвхөн цаасан дээрхи тайлан төдий болж, авсан арга хэмжээ нь хамрах хүрээ багатай, сургалт сурталчилгаа төдийхөнөөр хязгаарлагдсан үйл ажиллагаа болон хувирч байгааг холбогдох тайлангийн материалуудаас¹⁸ үзэхэд илхэн байна.

¹⁸ “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн 2008, 2009 оны тайлангууд

4. ТББ-УУДЫН ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгааны явцад дараахь томоохон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүжилтийн бүтэц, гишүүнчлэл, зохион байгуулалттай тэдний гарган өгсөн материал, интернет эх үүсвэр дээр үндэслэн танилцлаа. Залуучуудын төрийн бус байгууллагуудаас Монголын оюутны холбоо, Монголын Скаутын холбоо олон нийтийг хамарсан, хамгийн идэвхитэй олон талт үйл ажиллагааг явуулж буй нь ярилцлагын явцад болон цуглуулсан материалаас батлагдсан. Ярилцлагад орсон залуусын ярианаас дүгнэхэд Монголын Залуучуудын холбооноос хийгдэж буй ажлыг залуус хамгийн бага мэдэрдэг ажээ.

Зориг сан, Монголын Скаутын холбооноос бусад төрийн бус байгууллагуудын санхүүжилтийн мэдээлэл ил тод болж төлөвшөөгүй байна.

Намуудын дэргэдэх залуучуудын төрийн бус байгууллагуудын хувьд намын эгнээг өргөтгөх, сонгуульд намаа дэмжих үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байгаа ба залуучуудад тулгамдаж буй нийтлэг асуудлыг шийдвэрлэхээр төлөөлөн ажиллах, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага үндсэндээ алга. Залуу үе танхим, Монголын залуу эрдэмтэдийн холбоо зэрэг ТББ-нь нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага гэж өөрсдийгөө тодорхойлсон боловч үндсэндээ гишүүддээ үйлчлэх хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайланд хавсаргасан¹⁹ бусад жижиг төрийн бус байгууллагуудын хувьд мэдээлэл авах боломж байхгүй болон судалгааны ажлын цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаатай танилцах боломжгүй байсныг дурдая.

¹⁹ Мэдээллийг Ардчилалын боловсрол төвийн ТББ-уудын жагсаалтаас (DEMO) авав.

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
ЗАЛУУЧУУДЫН МЭРГЭШСЭН ТББ			
1	Монголын залуучуудын холбоо	<p>МЗХ нь 1991 оны 1 сард МХЗЭ-ийн бааз сурин дээр түүний албан ёсны залгамжлагчаар байгуулагдсан.</p> <p>Зорилго: Залуучууд эх орон, ард түмнийхээ төлөө бүтээлчээр ажиллаж амьдрах, шинийг санаачлах сэтгэлгээг төлөвшүүлж, оюуны болон бие бялдар, ёс зүйн зөв хүмүүжил олоход нь дэмжлэг үзүүлэх, ард түмнийхээ түүх соёл, ёс заншлын уламжлалыг өвлүүлэх, залуучуудын хөгжлийг урамшуулан дэмжих, тэдний дэлхий ертөнцөд хөл тавихад туслах явдал юм.</p> <p>Үйл ажиллагааны үндсэн чиглэл</p> <p>МЗХ нь шинэ үеийнхний талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулахад идэвхтэй оролцохын зэрэгцээ түүнийг хэрэгжүүлэхэд залуучуудын өөрсдийнх нь идэвх санаачлага, орролцоог чухалчлан үзэж, энэ чиглэл дэх төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төв, орон нутгийн түвшинд гүйцэтгэж, залуучуудын талаар явуулах төрийн бодлогын хэрэгжилтэнд олон нийтийн хяналт тавих, залуучуудын нийтлэг хүсэл эрмэлзэл, эрх ашгийг илэрхийлнэ.</p> <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Монголын залуучуудын хөнгөлөлтийн картыг үйлчилгээнд нэвтрүүлсэн. • Оюутан, залуучуудад зориулж сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сургалт, семинарыг зохион явуулдаг. • Залуу удирдагч сан нь залуу удирдагчдыг дэмжих, ирээдүйн төр, нийгмийн зүтгэлтнүүд төрөн гарахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 	<p>Бүтэц, зохион байгуулалт МЗХ нь 21 аймаг, 9 дүүрэг, сум, үйлдвэр, аж ахуйн нэгж, албан газруудад 600 гаруй анхан шатны нэгжтэй 100 мянга гаруй идэвхтэн дэмжигчтэй.</p> <p>МЗХ-ны харьяанд “Залуу удирдагч сан”, Залуучуудын хөгжлийн “Полиси” төв, “Залуучуудын хөдөлмөрийн бирж”, “Цэнгээнт бүжгийн хөдөлгөөн”, Сэтгэл зүйн төв, “Залуу удирдагч оюутны клуб”, “Англи хэлтэй оюутнуудын клуб”, гадаад хэлний сургалтын төв ажиллаж байна.</p> <p>Санхүүжилт: Холбооныхоо байр буюу үл хөдлөх хөрөнгөө түрээслүүлж, түүгээрээ санхүүждэг.</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<ul style="list-style-type: none"> • Залуучуудын хөгжлийн Полиси төв нь судалгаа шинжилгээ, дүгнэлт, сургалт, хөдөлмөр эрхлэлт, төсөл хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг нь явуулдаг. • Оюутан залуучуудад англи хэлний мэдлэг олгох, мэдлэг чадварыг нь сайжруулах чиглэлээр “Англи хэлээр яригч оюутнуудын клуб”-ыг ажиллуулж байна. • “Үндэсний сайн дурынхан- хөдөөд” төсөл • Малжуулах төсөл • “Амьдрах ухаан – Залуучууд” төсөл • Хөдөлмөрийн биржийг ажиллуулж байна. • Монголын залуучуудын өдрийг жил бүрийн 8 сарын 25-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг. • “Үндэсний талархлын өдөр”-ийг жил бүр 11 сарын 20-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг. • Хайрын шүлгийн “Цагаан уул” яруу найргийн наадмыг улсын хэмжээнд зохион явуулдаг. • “Хаврын баяр” цэнгээнт бүжгийн улсын наадам • “Эврика” багш, оюутны эрдэм шинжилгээний бага хурал • Оны шилдэг оюутан шалгаруулах “Алма матер” ёслолын ажиллагаа • “Интер ном” мэдээлэл холбооны технологийн өдөрлөг • Оны залуу шалгаруулах ёслол “NEXT STOP” харшийн наадмыг зохион байгуулж, оны залуугаар шалгарсан залуучуудаар лекц уншуулдаг. • 6-р сарын 1 буюу “Эх үрсийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг. • Хил хамгаалах ерөнхий газартай хамтран “Эр зоригийн сургууль” өдөрлөгийг зохион явуулдаг. • 1999 оноос эхлэн хэд хэдэн удаа “Бүх нийтийн гүйлт”-ийг зохион байгуулсан. • 2003 оноос эхлэн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад Монголынхоо түүх, ёс заншлыг сурталчлах зорилгоор Монголын Үндэсний түүхийн музейг 	

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>үнэ төлбөргүйгээр үзүүлэх ажлыг МҮТМ-тэй хамтран зохион байгуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Залуучуудын дунд гадаад хэлний, мэргэжлийн чиг баримжаа олгох, экологийн боловсрол мэдлэг олгох, эрүүл мэнд, эрх зүйн боловсрол олгох, гэр бүл төлөвлөлтийн, ДОХ, БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх, удирдах ажилтны, жолооны гэх мэт олон сургалтуудыг зохион явуулдаг. 	
2	Монголын оюутны холбоо	<p>1990 оны 12 дугаар сарын 02-нд Монголын оюутны холбооны III чуулган Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, чуулганаар бие даасан, хэнээс ч хараат бус ажилладаг, оюутны эрх ашгийг хамгаалагч, оюутны төрийн бус төв байгууллага болохийг тодорхойлсон. Харин өнөөдрийн МОХ нь 2001 оны 05-р сараас шинэчлэгдэн зохион байгуулагдаж оюутнуудынхаа нийгмийн хамгааллыг бүрдүүлэн сайжруулах, тэдэнд үзүүлэх хөнгөлөлтийг олон улсын оюутны жишгийн дагуу эдлүүлэх талаар санаачлагатай ажиллаж хэрэгжүүлэх, оюутнуудыг олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн чадварлаг боловсон хүчин болгон төлөвшүүлэх чиглэлээр амлалт аван "2005-2010 онд хэрэгжүүлэх Монголын оюутны хөгжлийн хөтөлбөр"-ийн дагуу ажлаа төлөвлөн хэрэгжүүлж байна.</p> <p>МОХолбоо нь Монгол Улсын төрийн болон төрийн бус бүхий л байгууллагуудаас хамгийн анх буюу 1945 онд НҮБ-ын гишүүн статустай Олон улсын Оюутны холбооны жинхэнэ гишүүнээр элссэн. Олон улсын оюутны холбоо, Олон улсын оюутны спортын холбоо, Азийн оюутны холбоо, Азийн оюутны мэдээллийн төв, Олон Улсын оюутны аялал жуулчлалын холбоо, Төв Азийн Оюутны холбоо, ОХУ-ын Оюутны холбоотой хамтран ажилладаг.</p> <p>Зорилго: МОХ-ны зорилго нь олон улсын гэрээ конвенцид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд болон Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар олгосон оюутны эрх, ашиг сонирхолыг Монгол</p>	<p>Бүтэц, зохион байгуулалт</p> <p>МОХолбоо нь дэргэдээ 170 гаруй их, дээд сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг оюутны анхан шатны 320 орчим сайн дурын үйл ажиллагаатай байгууллага, клубууд багтдаг.</p> <p>Оюутны анхан шатны байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллежи, мэргэжлийн сургуулиудын оюутны өөрөө удирдах ёсны байгууллага бөгөөд МОХ-ны жинхэнэ гишүүн байгууллага байна. Оюутны бие даасан бусад байгууллагууд МОХ-ын зөвлөх гишүүн байгууллагаар элсэж болдог.</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>Улсын болон олон улсын хэмжээнд төлөөлөн хамгаалах, тэдний бие даан хөгжих бүхий л нөхцөл бололцоог хангахад оршино.</p> <p>Үйл ажиллагааны үндсэн чиглэл</p> <ul style="list-style-type: none"> • Оюутан түүний боловсрол эзэмших эрхтэй холбогдсон бүхий л асуудлаар тооцоо, судалгаа, шинжилгээ хийж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас оюутан болон боловсролын талаар баримтлах бодлого, шийдвэрийн төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай оролцох, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих; • МОХ жинхэнэ болон зөвлөх гишүүн оюутны байгууллагуудын бие даан ажиллах эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэн, гадаад, дотоодын төрийн, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах боломжоор хангахад идэвхи санаачлагатай оролцох; • Монголын оюутны хөдөлгөөний эв нэгдлийг хамгаалан хөгжүүлэх, оюутны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага арга зүйн зөвлөгөө өгөх, тэдгээрийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх, мэдээлэл санал бодлоо чөлөөтэй солилцож, илэрхийлэх бүх талын бололцоог бүрдүүлэх, • Олон улсын түвшинд Монголын оюутны хөдөлгөөнийг төлөөлөн ажиллаж олон улс, бүс нутгийн оюутны хөдөлгөөнд МОХ-ны гүйцэтгэх үүргийг бий болгох, Монголын оюутны гадаад харилцаа, олон улсын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж хөгжүүлэх; • Оюутны нийгмийн асуудлыг төрийн байгууллагын оролцоотой шийдвэрлүүлэн оюутны дунд эрдэм шинжилгээ, урлаг спорт, соёлын олон төрөлт арга хэмжээг зохион байгуулах, чөлөөт цагыг нь үр бүтээлтэй өнгөрүүлэх шинэ төрлийн ажлыг үүсгэн хөгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлж, оюутны нийтлэг эрх ашгийг төлөөлөн хамгаалах; 	<p>Санхүүжилт</p> <ul style="list-style-type: none"> • Жинхэнэ болон зөвлөх гишүүн байгууллагын татвар, хандив • Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого • Зээл, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон бусад байгууллагаас олгосон хөрөнгө • Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • МОХ болон түүний салбар холбоод бусад байгууллагуудтай хамтран нийт 51 тогтмол үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> – Оюутны ЭШ –ний бага хурал (Эврика) – Оюутны бизнес бүтээлч сэтгэлгээний уралдаан (Монгол улсаа хөгжүүлье) – Уран илтгэлийн тэмцээнүүд- Монгол бахархал – Оюутанд зориулсан цуврал лекц, семинар сургалтууд – Эрүүл мэндийн боловсрол арга хэмжээ (архи, тамхины эсрэг, эрүүл амьдрах зан үйлийг дэмжих, ДОХ-ын эсрэг гэх мэт)- Оюутны эрүүл мэндийн үзлэг – Нийгмийн тустай үйл ажиллагаа – Оюутны урлагийн наадам, соёлын өдөрлөг – “Венус”, “Хаврын баяр” арга хэмжээ – Оюутны спорт нийтийн биеийн тамирын арга хэмжээ – Ажлын байр зуучлах • Оюутны тэтгэлэг хөтөлбөрийн талаар мэдээллийг түгээх, түүнийг олгох ажилд оролцох зохион байгуулсан • Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит грант, шагналыг шалгаруулах зохион байгуулсан • Оюутнуудын нийтийн унаа, тээврээр үнэгүй зорчих хөнгөлөлтийн картыг олгох ажлыг зохион байгуулдаг. • Оюутан залууст шаардлагатай мэдээ мэдээ мэдээллийг түгээх <p>http://www.student.org.mn- веб хуудсан дээр мэдээллүүд сайн тавигдсан.</p>	
3	Монголын залуу эрдэмтдийн холбоо	ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтан залуучуудын байгуулсан “Монголын Эрдэм Шинжилгээний Ажилтан Залуучуудын Холбоо”, Эрүүл мэндийн	Бүтэц, зохион байгуулалт:

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>шинжлэх ухааны их сургуулийн багш судлаачдын “Анагаахын Залуу Судлаачдын Холбоо” зэрэг хэд хэд төрийн бус байгууллагууд өөрийн зорилго, үзэл санаагаа нэгтгэн Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо” төрийн бус байгууллагыг 2004 онд үүсгэн байгуулсан.</p> <p>Монголын Залуу Эрдэмтдийн холбоо ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, төрийн бус байгууллага юм.</p> <p>Зорилго: Дотоод гадаадад эрдэм шинжилгээний ажил эрхэлж буй Монгол Улсын иргэн залуу судлаач, эрдэмтэд бүх талын дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, гадаад орнуудын залуу эрдэмтэдтэй хамтран ажиллах, гадаадад болон дотооддоо мэдлэгээ дээшлүүлэн сурч ажиллахад нь туслалцаа үзүүлэхэд оршино.</p> <p>Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Судлаач, эрдэмтэн залуучуудын судалгааны ажлыг дэмжин туршлага солилцуулах, • үндэсний болон олон улсын хэмжээнд эрдэм шинжилгээний хурал, чуулга уулзалт, сургалт-семинар зохион байгуулах • Холбооны гишүүдийг мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэн дотоод, гадаад оронд сурч ажиллахад дэмжлэг үзүүлэх • Төрийн ба төрийн бус байгууллагууд, хувь хүмүүстэй үндэсний болон олон улсын хэмжээнд хамтарсан төсөл хэрэгжүүлэх, <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Залуу эрдэмтэн судлаачдын чуулган уулзалтыг зохион байгуулдаг. • Залуу эрдэмтэн судлаачдын туршлага солилцох, бүтээлээ олны хүртээл болгох ажлыг дэмжих зорилгоор “Хүрэл тогоот” эрдэм шинжилгээний бага хурлыг жил бүр зохион байгуулж байна. 	<p>Холбоо нь бүтцэндээ Анагаах, Байгаль, Биологи, хөдөө аж ахуй, Геологи, газар зүй, Нийгэм, хүмүүнлэг, Техник, технологийн ухааны гэсэн 6 салбар холбоодтой байна. Нийт гишүүдийн тоо 1000 Холбооны гишүүнээр 18-35 насны өмчийн бүх хэлбэрийн эрдэм шинжилгээний болон үйлдвэр, аж ахуйн байгууллага, их дээд сургуулиудад ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, судлаач, багш, оюутан элсэж болно.</p> <p>Санхүүжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Гишүүдийн татвар • Салбар холбоод болон сайн дурынхны хандив • Төрийн ба төрийн бус байгууллагын үйл ажиллагааны оролцооны хэлбэрээр өргөх хандив • Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс (Шинжлэх ухаан технологийн сан) олгосон хөрөнгө • Төсөл хэрэгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагаас олгосон мөнгөн хөрөнгө, тусламж

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<ul style="list-style-type: none"> • Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэж буй залуу судлаачдыг дэмжих зорилготой, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналыг (1 сая төгрөг) 2001 оноос, БСШУ-ны Сайдын нэрэмжит “Залуу Эрдэмтэн шинжилгээний ажилтуудыг дэмжих грант”-ыг (2 сая төгрөг) 2005 оноос гардуулж эхлээд байгаа бөгөөд 35–аас доош насны залуу судлаачдад олгох ажлыг зохион байгуулдаг. • Залуу эрдэмтэн судлаачдын дунд “Эко-Явган аялал” нийгмийн тустай үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж байна. • Үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний инновацийн хөтөлбөр, Шинжлэх ухаан, технологийн мастер төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулахад тус холбооны залуучууд баг болон амжилттай оролцож байсан. • 2004 онд Дэлхийн Залуу Эрдэмтэдийн Академийн гишүүн байгууллага болж түүний үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна. <p>http://mysamzeh.blogspot.com</p>	
4	Залуу үе танхим-JCI	<p>Залуу үе танхим 1991 онд зохион байгуулагдаж, 1995 онд Дэлхийн Залуу үе танхимын 51 дэх гишүүн байгууллага болон элсэн орсон.</p> <p>Эрхэм зорилго: Дэлхийн JCI байгууллагын үндсэн зарчим, тунхаглалд тодорхойлсоноор нийгэмд нааштай өөрчлөлт бий болгох, залуучуудын удирдах чадварыг хөгжүүлэх, нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, ажил хэрэгч бизнес эрхлэгчдийн харилцааг хөгжүүлэхээр болж буй болжлоо Монголын болон хүн төрөлхтөний хөгжилд хувь нэмрээ оруулах гэж тодорхойлжээ.</p> <p>Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Бизнес – гишүүдийн бизнесийн туршлагыг дээшлүүлэх сургах, • Гадаад харилцаа – дэлхийн бусад залуучуудтай нөхөрлөх үзэл бодлоо 	<p>Бүтэц, зохион байгуулалт:</p> <p>Залуу үе танхим одоогоор Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Капитал, Их Хүрээ, УБ Централ, Лидер гэсэн 7 салбар үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 400 орчим гишүүд, 30 гаруй сенатор (40-оос дээш насны гишүүд), 20 сениор бүхий байгууллага болжээ.</p> <p>18-40 хүртэлхи насны залуучууд гишүүн, дэмжигчээр үйл ажиллагаанд оролцдог.</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>солилцох, соёл ёсзаншилтай танилцах боломж олгох,</p> <ul style="list-style-type: none"> • Олон нийт – гишүүн залуучуудын нийгмийн идэвхитэй үйл ажиллагаанд татан оролцуулах, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа хэрэгжүүлэх • Хувь хүн – залуучуудын итгэл, бүтээлч сэтгэлгээг бий болгох, удирдах чадвар эзэмшүүлэх, залуу удирдагчдыг бэлдэх <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Дотоод <ul style="list-style-type: none"> – Гишүүн залуучуудын дунд бизнес мэдээг түгээх сургалт семинар зохиох – Оюутан залуусын дунд илтгэх урлагийн тэмцээн, сургалт семинар хэрэгжүүлэх – Залуу бизнесменүүдийг дэмжих чиглэлээр олон улсын төсөл, худалдаа бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах – Нийгэмд тустай буяны үйл ажиллагаа явуулах • Гадаад <ul style="list-style-type: none"> – Дэлхийн болон бүс нутгийн JCI-ийн чуулга уулзалт, Академид оролцох – JCI-ийн Дэлхийн нийтийн сургалт хөтөлбөрт хамрагдах – Бусад орны салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллах – Олон улсын сургалт семинар эх орондоо зохиох <p>http://www.jci.cc/local/mongolia-mn</p>	<p>Санхүүжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Гишүүдийн татвар (өндөр) • Хандив
5	Монголын скаутын холбоо	Тус холбоо 1992 онд байгуулагдсан. Скаутын хөдөлгөөн нь анх энэхүү хөдөлгөөнийг үндэслэгчийн боловсруулсан зорилго, зарчим, аргад нийцүүлэн хүүхэд, залуучуудыг хүмүүжүүлэх, улс төрийн бус, аливаа хүний гарал үүсэл, арьсны өнгө, шашин шүтлэгээс үл хамаарах, нийтэд нээлттэй, сайн дурын хөдөлгөөн юм. 1992 оноос хойш нийт 60000 гаруй мянган хүүхэд залуучууд	<p>Бүтэц, зохион байгуулалт:</p> <p>21 аймаг, 9 дүүрэгт салбар зөвлөлтэй. Нийт 9000 гаруй хүүхэд, залуучууд, 1000 гаруй насанд хүрэгчид скаутын хөдөлгөөнд хамрагдаж байна.</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>хүмүүжин гарсан.</p> <p>Эрхэм зорилго: Скаутын андгай хуульд тулгуурлан залуу үеийнхний боловсролд хувь нэмэр оруулж, ирээдүйн амьдралаа цогцлон байгуулах, нийгэмд бүтээлч байр суурь эзлэх, бие даасан хувь хүмүүсийг төлөвшүүлэхэд туслана.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • залуу үеийнхнийг албан бус боловсролын хүрээнд хамруулах, • тодорхой арга хэрэглэн залуу хүн бүрийг өөрийгөө хөгжүүлэх явцад бие даасан, тусч, хариуцлагатай, өөрийгөө дайчлах чадвартай болгох, • Скаутын андгай, зарчимд тусгасан, оюун санаа, нийгмийн болон хувийн үзэл баримтлалд тулгуурлан өөрийгөө төлөвшүүлэх <p>Хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Скаутын холбооны гишүүдийн зуслан цугларалт • Скаутын удирдагчдын сургалтыг тогтмол зохиож байна. • “Амьдралд хүрэх тасалбар” хөтөлбөр - хүүхэд асран хүмүүжүүлэх газартай хамтарсан орон гэргүй, хараа хяналтгүй, өнчин хүүхдүүдийн скаутын бүлэг байгуулах арга хэмжээг зохион байгуулсан. • Скаутын зуслан болон Баянгол олон нийтийн төвийг байгуулсан. • “Ногоон дэлхийгээ аварцгаая” сэдэвт скаутын аялалыг тогтмол зохиож байна. • Орон нутгийн тойрон аялалын хөтөлбөрүүд • Гадаад хамтын ажиллагаа, тусламжийг эрчимжүүлсэн- Дани Балба, АНУ, Герман, Япон, Франц, Филиппин, Люксембург <p>http://www.scout.mn</p>	<ul style="list-style-type: none"> • Кабууд — 6-11 насны охид, хөвгүүд • Скаутууд — 12-16 насны охид, хөвгүүд • Венчирүүд — 17-18 насны охид, хөвгүүд • Роверууд — 19-25 насны залуучууд • Анхан шатны нэгжид ажиллах удирдагчид, үүрэгт ажилтнууд, Скаутын үйл ажиллагааг дэмжигч насанд хүрэгчид <p>Санхүүжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Гишүүний татвар, хандив • Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив • Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого (Гэрсэнз компаний хувьцааны 54 хувийн ногдол ашиг) <p>Байгууллагын гишүүд нь гишүүний татварыг дараах хэмжээгээр төлнө.</p> <ul style="list-style-type: none"> • УЗ-ийн гишүүд – 100.000 төгрөг • Үндэсний Зөвлөлийн Товчооны гишүүд – 20.000 төгрөг • Хяналтын Зөвлөлийн гишүүд – 20.000 төгрөг

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
			<ul style="list-style-type: none"> • Аймаг дүүргийн Скаутын зөвлөлийн Дарга болон сонгуульт гишүүд, дэмжигчид – • 5.000 төгрөг • Анхан шатны нэгжийн удирдагч, гишүүд – 1.500 төгрөг • Каб, скаут, венчир, роверууд – 1.000 төгрөг
6	НҮБ-ын дэргэдэх Залуучуудын зөвлөх хороо	<p>НҮБ-ын Хүн амын сангийн дэргэд Залуучуудын зөвлөх хороог 2006 онд байгуулсан.</p> <p>НҮБ-ын дэргэдэх Залуучуудын Зөвлөх Хороо (ЗЗХ) нь НҮБ-аас Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн талаарх мэдлэг ойлголтыг хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад хүргэх, мөн тэдгээр хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээнд хүүхэд, залуусыг төлөөлөх, оролцоог хангах зорилготой залуусын сайн дурын, зөвлөх баг юм.</p> <p>Зорилго: НҮБ-ын Монгол дахь хөтөлбөрийн боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт, мониторинг, үнэлгээний үйл явцад залуучуудын дуу хоолойг хүргэж, бүх түвшинд залуучуудын идэвхтэй харилцааг хөгжүүлэхэд оршино.</p> <p>Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Залуучуудын хөгжилд нөлөөлж буй шинэ асуудлууд болон НҮБ-ын хөтөлбөрүүдэд залуучуудыг оролцуулах боломжуудыг тодорхойлох • НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудад залуучуудын гаргасан санаачлага, хөтөлбөрийн талаарх мэдээлэл, мэдлэгийн солилцоог дэмжиж, тасралтгүй түгээх, зөвлөгөө өгөх, үндэсний болон орон нутгийн түвшинд дэмжих • Залуучуудын хөгжлийн төлөөх үйл хэргийг дэмжиж, хамтын үйл ажиллагааг өргөжүүлж, гадаад дотоодын түншүүдтэй явуулах хамтын 	<p>Бүтэц, зохион байгуулалт:</p> <p>ЗЗХ нь одоогоор 1 зохицуулагч, хүүхэд, залуучуудын байгууллагын төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэйгээр Монгол дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>Гишүүн байгууллагууд:</p> <ul style="list-style-type: none"> • Монголын улаан загалмайн нийгэмлэг • МОХ • Монголын эрэгтэйчүүдийн холбоо • Монголын скаутын холбоо • Монголын хүүхдийн байгууллага • “Оюуны чадвар- Хүний хөгжил” төв • “Ирээдүйн босго” Өсвөр үеийн

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>ажиллагааг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> • НҮБ-ын өдөр, олон улсын тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх болон бусад томоохон арга хэмжээ, кампанит ажлуудыг дэмжих, бие даан зохион байгуулах • НҮБ-ын Хүн амын сангийн дэргэдэх дэлхийн ЗЗХ болон бусад орны залуучуудын зөвлөх хороодтой холбоо тогтоон хамтран ажиллах • НҮБ болон ЗЗХ-ны талаарх мэдээллийг хэвлэмэл хуудас, цахим хэлбэрээр тасралтгүй түгээх <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • 2010-2011 оныг НҮБ-аас “Олон улсын залуучуудын жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын ГХЯ-тай хамтран тус жилийн нээлтийн ёслол ажиллагааг зохион байгуулсан. • Залуучуудын жилийн хүрээнд залуучуудыг соёл урлагтай танилцуулах, тэдний нийгмийн оролцоог дэмжих зорилготой Эрх чөлөөний парад зохион байгуулсан. • Залуучуудын эрүүл мэндийн боловсрол, нийгмийн оролцоог дэмжсэн жижиг төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. • Гадаадын болон дотоодын тэтгэлэгт хөтөлбөрүүдийн мэдээллийг оюутан залууст хүргэх, түгээх ажлыг зохион байгуулж байна. • 2010 оны 10-р сард Залуучуудын анхны Ассамблейг зохион байгуулна. <p>www.yap.mn</p>	<p>эрүүл мэндийн төв</p> <ul style="list-style-type: none"> • “Үерхэл Love” сонин • “ТУНЗА” сэтгүүл <p>Санхүүжилт: НҮБ-ын Хүн амын сангийн төсөл хөтөлбөрийн хүрээнд</p>
НАМУУДЫН ДЭРГЭДЭХ ЗАЛУУЧУУДЫН ТББ			
1	МАСЗХ-Нийгмийн ардчилал, залуучуудын холбоо	1994 онд МАХН-ын дэргэд Залуу гишүүд, дэмжигчдийн зөвлөл нэрээр байгуулагдсан. 1996 онд Залуучууд хөгжил төв болон өргөжсөн ба 1997 онд Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбоо гэсэн улс төрийн чиг баримжаа бүхий залуучуудын ТББ болон зохион байгуулсан. 2010 оны 9 дүгээр сард тус холбоо нэр, үзэл баримтлалаа өөрчилж Нийгмийн ардчилал,	<p>Бүтэц, зохион байгуулалт:</p> <p>Нийт 21 аймаг, 9 дүүрэг, 329 суманд салбар холбоо байгуулан ажиллаж</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>залуучуудын холбоо болсон.</p> <p>Эрхэм зорилго: Нийгмийн ардчилсан социалист үзэл санааг нийгэмд төлөвшүүлэх, дэлгэрүүлэх эрмэлзэл бүхий залуучуудын хүсэл сонирхлыг илэрхийлэн хамгаалж улс орны хөгжил дэвшилд залуу хүн бүрийн оролцоог хангахад оршино.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн ардчилсан үзэл санаанд итгэх олон түмний итгэлийг бэхжүүлэх, дэмжигчдийн хүрээг өргөтгөх • Залуучуудын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох • МАХН-аас намын гишүүн, дэмжигч болон нийт залуучуудын талаар баримтлах бодлогыг тодорхойлон боловсруулахад оролцох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах • Залуучуудын нийтлэг эрх ашигт нийцсэн төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах, хүүхэд залуучууд, оюутан, эмэгтэйчүүд, ахмад, ҮЭ-ийн болон бусад ТББ-тай хамтран ажиллах • ОУСЗХ, түүний гишүүн байгууллагууд болон гадаад орны ижил төстэй байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллах <p>Хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • ОУСЗХ-ны гишүүнээр 2002 онд элссэн. • “Бид эх орондоо хайртай” шоу тоглолт 2010 онд зохион байгуулсан. • Сонгуулийн үйл ажиллагаанд намын гишүүдийг дэмжихэд идэвхтэй үйл ажиллагааг явуулдаг. • Гишүүн залуучуудын дунд урлаг, спорт, соёлын арга хэмжээг зохион байгуулдаг. • Нийгмийн ардчилсан үзэл баримтлалын үнэт зүйлсийг сурталчилсан 	<p>байна. Дүрэм ёсоор 35 хүртэлх насны залуусыг гишүүн байхаар заасан.</p> <p>Санхүүжилт:</p> <p>Тус холбооны дүрэмд зааснаар аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, гишүүний татвар, дэмжигч хувь хүн, байгууллага, хамт олны хандиваас тус холбооны үйл ажиллагааны зардал болон өмч хөрөнгө нь бүрдэнэ. Гишүүдийн татвар, хандив өргөх журмыг тус холбооны УЗ баталдаг.</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>“Багийн спортыг хөгжүүлэх” хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • 18-25 насны залууст чиглэсэн “Залуус” дэд хөтөлбөр хэрэгжүүлэх • “Хорт зуршлаас сэргийлэх хөтөлбөрүүд”-ийг хэрэгжүүлэх 	
2	МАСОХ	<p>1998 оны 11 сард ардчилсан социалист үзэл баримтлалыг дэмжигч оюутан залуусын санаачлагаар байгуулагдсан ТББ болно.</p> <p>Эрхэм зорилго: Нийгмийн ардчилсан үзэл санааг дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх эрмэлзэл бүхий оюутан залуусын хүсэл сонирхол, эрх ашгийг илэрхийлэн хамгаалахад оршино.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Оюутан залуучуудад нийгмийн ардчилсан үзэл баримтлалыг сурталчлан таниулах улс төрийн олон талт мэдээллийг тогтмол хүргэж байх • Оюутан залуучуудад тулгамдаж буй асуудлаар бодлого боловсруулж, үүнийг шийдвэрлэхэд МАХН-ын Удирдах зөвлөлтэй хамтран ажиллах • Оюутан залуусын чөлөөт хөгжлийг дэмжих, оюутнуудын дунд эрдэм шинжилгээ, соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах • МАХН-ын дэргэдэх ТББ-уудтай хамтран ажиллах <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • 2009 оныг тус холбооноос “Оюутны оролцооны жил” болгон зарлаж тэдэнд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан. • Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлсэн. • Мэтгэлцэх, илтгэх урлагийн уралдааныг улирал тутам зохион явуулдаг. • Оюутнуудын урлагийн их наадмыг жил бүр зохион байгуулдаг. • Илтгэх, мэтгэлцэх урлагийн сургалтыг Мэтгэлцээний нэгдсэн 	<p>Бүтэц, зохион байгуулалт: Тус холбоо нь Улаанбаатар хотын бүх дүүрэг, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв бүхий аймгуудад өөрийн салбар холбоодтой. Холбооны нийт гишүүд дэмжигчдийн тоо 50 мянга. Тус холбооны Ерөнхий чуулганаас 25 гишүүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөлийг сонгодог.</p> <p>Гишүүнээр насны хязгааргүйгээр нийгмийн ардчилсан үзэл санааг дэмждэг оюутан залуус элсэх боломжтой.</p> <p>Санхүүжилт: Тус холбооны дүрэмд зааснаар аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, гишүүний татвар, дэмжигч хувь хүн, байгууллага, хамт олны хандиваас тус холбооны үйл ажиллагааны зардал болон өмч хөрөнгө нь бүрдэнэ. Гишүүдийн татвар, хандив өргөх журмыг тус</p>

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж байна.	холбооны УЗ баталдаг.
3	МоАЗХ	<p>2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Ардчилсан намын албан ёсны залуучуудын байгууллага болох Ардчилсан Залуучуудын Холбоо үүсгэн байгуулагдсан.</p> <p>Эрхэм зорилго: Монгол Улсын хөгжил дэвшилд өөрсдийн хувь нэмрийг оруулах, ардчилсан үзэл санаа, ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, нээлттэй нийгмийг төлөвшүүлэх, залуучуудын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, төр болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад залуучуудын төлөөллийг нэмэгдүүлэх, төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого, гарах шийдвэрт нөлөөлөх, түүнийг гардан хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцох явдлыг зоилгоо болгосон.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Ардчилсан намын бодлого, үйл ажиллагааг дэмжиж ажиллах, • гишүүн, дэмжигч залуучуудын нийгэм, улс төрийн идэвхи, оролцоог дэмжих, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад залуучуудын төлөөллийг нэмэгдүүлэх, • залуучуудыг чадваржуулах, тэдний улс төрийн боловсролыг дээшлүүлэх, • олон улсын ижил төстэй залуучуудын байгууллагуудтай хамтран ажиллах <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • "Ардчилсан хувьсгал ялаагүй байсан бол" сэдэвт оюутан залуус өсвөр үеийнхэний дундах эссе бичлэгийн уралдаан • Лектор төв хамтран илтгэх урлагийн онол, арга зүйн “Реторик” сургалтыг 2010 оны 8 дугаар сарын 16-20-ний өдрүүдэд зохион байгуулав. Үүнд хөдөө орон нутгийн 40 гаруй залуус хамрагдсан. • Хойд бүсийн залуучуудын, “Айсуй цагийн эзэд-2010” орон нутгийн залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулсан. 	<p>Бүтэц зохион байгуулалт:</p> <p>Ардчилсан Залуучуудын Холбоо нь Ерөнхийлөгч, 4 Дэд Ерөнхийлөгч, Бага чуулганы 82 гишүүн, Удирдлагын зөвлөлийн 56 гишүүн, Хяналтын зөвлөлийн 5 гишүүн, Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын нийслэл, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг, бүх сумдад салбар байгууллага, залуучуудын сайн дурын 12 гишүүн байгууллага, нийт 60 гаруй мянган гишүүн, дэмжигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тус холбооны Ерөнхийлөгчөөр Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Б.Болор сонгогдон ажиллаж байна.</p> <p>Санхүүжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Гишүүний татвар, хандив, • Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив • Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<ul style="list-style-type: none"> ХБНГУ-ын Баден Вуртемберг мужийн “Asia circle” сангаас хэрэгжүүлж байгаа “Германы залуу элч нар Азид” хөтөлбөрийн хүрээнд Германы залуусын соёлын арга хэмжээтэй айлчлал, 2 орны залуусын уулзалтыг 2010 оны 8-р сард зохион байгуулав. www.demyouth.mn	<ul style="list-style-type: none"> Өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олсон хөрөнгө Гэрээт төслийн хөрөнгө Бусад хууль ёсны
4	Иргэний зориг залуучуудын холбоо	<p>2005 оны 12 сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан.</p> <p>Эрхэм зорилго: Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах, ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхээр зорьж буй ИЗН-ын үйл ажиллагааг дэмжих, залуучуудын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, төрийн болон өөрөө удирдах ёсны байгууллагуудад залуучуудын төлөөллийг нэмэгдүүлэх, төрөөс залуучуудын талаар явуулж буй бодлого, гаргах шийдвэрт нөлөөлөх, түүнийг гардан хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох явдлыг зорилгоо болгосон.</p> <p>Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> өөрсдийн дэмжигчдийн хүрээг өргөтгөх, залуучуудын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, залуучуудын хүсэл сонирхолд нийцсэн төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах, оюутан залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> “Монгол улсаа хэрхэн хөгжүүлэх вэ?” эссэ бичлэгийн уралдаан Холбооны дэргэдэх Иргэний зориг оюутны холбоо оюутан залууст чиглэсэн спорт урлагийн арга хэмжээ зохиодог www.zaluus.mn , www.izn.mn	Мэдээлэл байхгүй,

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БУСАД ТББ			
1	Зориг сан	<p>Зориг сан нь 1998 онд Талийгаач С. Зоригийн дотны нөхөд, хамтран зүтгэгчид, гэр бүлийн зарим гишүүдийн санаачилсанаар анх үүсэн байгуулагдаж нийгэмд үйлчилдэг, ашгийн бус, төрийн бус байгууллага юм.</p> <p>Эрхэм зорилго: Монгол оронд ардчилсан нийгмийг төлөвшүүлэн хөгжүүлэх, улс төрийн шинэчлэлийг дэмжих, иргэдэд ардчиллын үнэт зүйлсийг хэвшүүлэх, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн шударга ёсыг хамгаалах, олон ургальч үзлийг хүндэтгэх, төр засгийн үйл ажиллагааг нийгэмд нээлттэй байлгах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахад оршино.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Залуучуудын улс төр, иргэний боловсролыг дээшлүүлэх, ардчилалд тэдний оролцоог нэмэгдүүлэх • Ил тод байдал, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх болон авлигын эсрэг үзэл санааг сурталчилах, олон нийтийг энэ чиглэлд гэгээрүүлэх • Хүний эрх, эрх чөлөөг хамгаалж баталгаажуулах хууль зүйн актыг боловсронгуй болгох <p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөрүүд <ul style="list-style-type: none"> – Японы “Осака төв ротари” клубын тэтгэлэгт хөтөлбөр – Швейцарийн хөгжлийн агентлагийн тэтгэлэгт хөтөлбөр – Хан Ресорсез ХХК-ийн Дорнодын оюутнуудад зориулсан тэтгэлэгт 	<p>Санхүүжилт</p> <ul style="list-style-type: none"> • Түрээсийн орлого • Олон улсын төсөл хөтөлбөрөөс үйл ажиллагааны хандив, тусламж • Нийгмийн хариуцлагатай компаниудын хандив, төсөл, хөтөлбөр

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
		<p>хөтөлбөр</p> <ul style="list-style-type: none"> - “Металь Тек” ХХК-ийн тэтгэлэгт хөтөлбөр • Залуучуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажил мэргэжлээрээ өсөх боломжоо нээхэд нь дэмжлэг үзүүлэх, түлхэц болох зорилготой “Залуу лидер хөтөлбөр”-ийг (сургалт семинар) АНУ дахь Зориг сан болон Хаан Банк сангийн санхүүжилтээр үндэсний болон гадаадын туршлагатай мэргэжилтэн, лидерүүдийг оролцуулан зохион байгуулж байна. • Сургуулиудын түншлэл- Зориг сан нь Улаанбаатар-Денверийн Ах дүү хотуудын зөвлөл болон АНУ дахь Зориг сантай хамтран хоёр орны ерөнхий боловсролын сургуулиудын хооронд түншлэл тогтоох төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд оролцогч сургуулиудын сурагч, сургуулийн удирдлага, багш нарын хооронд харилцаа тогтоож, түүх соёлын болоод боловсролын чиглэлээр хамтран ажиллах боломжтой болдог. • Англи хэлээр яригчдын улсын уралдаан- Зориг сан Монголын англиар яригчдын холбоотой (ESUM) хамтран жил бүр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин Сайдын Яамны ивээл дор, ХААН Банк Сангийн ивээн тэтгэлгээр Англи хэл дээрх уран илтгэлийн улсын уралдааныг 16-20 насны оюутан8 сурагчдын дунд зохион байгуулж байна. <p>http://www.zorigfoundation.org/mn/</p>	
2	Монголын сурагчдын холбоо	Н.Отгонцэцэг- гүйцэтгэх захирал	oonzoo_87@yahoo.com
3	Принцесс төв	Хатагтай Ундрах	info@princesscenter.org

“Залуучуудын бодлого” судалгааны тойм

№	Төрийн бус байгууллага	Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл	Бүтэц, гишүүнчлэл, санхүүжилт
4	Дэлхийн Энхтайвны төлөөх Монголын залуучуудын холбоо	Г.Бат-Орших – гүйцэтгэх захирал	www.yfwp.mn
5	Хөгжлийн цонх	Б.Цэвэлмаа – гүйцэтгэх захирал	tseveljin@yahoo.com
6	Монголын эмэгтэйчүүдийн сан - Залуу лидер эмэгтэйчүүдийн клуб	Д.Баярмаа - Зохицуулагч	bayarma_h@yahoo.com
7	Монголын лектор төв	Ц.Баатархүү - гүйцэтгэх захирал	ts_baatarkhuu@yahoo.com
8	Монголын хүүхэд, насанд хүрэгчдийг дэмжих төв	Л.Жаргалсайхан – ажилтан	jar_hul@yahoo.com m_sharlota666@yahoo.com

5. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОЙМ ДҮГНЭЛТ

Тус судалгааны ажлын хүрээнд манай улсад залуучуудад тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэж буй төрийн бодлогын хэрэгжилт, бодлогыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын талаар тойм дүр төрхийг гаргахыг оролдлоо.

Юуны түрүүнд залуучууд гэдэг ойлголтонд ямар насны бүлгийн хүмүүс хамаарах талаар Монгол Улсын хууль эрхзүйн баримтууд, судлаачдын гаргасан санал дүгнэлт, олон улсын түвшинд хэрхэн ойлгодог, манай орны нөхцөлд олон нийт хэрхэн үздэг талаар болон өсвөр үе залуучуудад чиглэсэн бодлогын хүрээнд хэрхэн авч үзсэн зэргийг харьцуулан судаллаа. Үүний үндсэн дээр **15-35 насны хүмүүсийг залуу насны бүлэгт хамаатүүлж үзэх нь зүйтэй** гэсэн өөрийн санал дүгнэлтийг хийж байна. Энэхүү дүгнэлтээр залуучуудад хамаарах насны бүлгийн хүмүүс нь манай улсын хүн амын 40 орчим хувийг эзэлж байгаа нь тэдний нийгэм, эдийн засгийн чиглэлээр авах төрийн бодлогын цар хүрээ хэчнээн өргөн болохыг харуулна.

Судалгааны ажлын дараагийн зорилт нь өнөөдөр манай залуучуудад тулгамдаж буй нийгмийн асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлон гаргах ажил байлаа. Манай залуучуудад дэлхийн бусад орны залуусын нэгэн адил чанартай боловсрол, мэргэжил эзэмших, зохистой хөдөлмөр эрхлэлтээр өөрийгөө болон гэр бүлээ авч явах нөхцөл боломжоор хангагдах, бие даасан хүн болон төлөвшихөд шаардлагатай мэдлэг мэдээллийг олж авах, тэдний нийгмийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх зэрэгт тулгамдаж буй нийтлэг хүндрэл бэрхшээлүүд оршсоор байна. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийн хүндрэлүүд, ажилгүйдэл ядуурал, нийгмийн өнөөгийн сэтгэлзүйн гутранги үзэл бодол, төрийн уялдаагүй бодлогын үр дагавар зэргээс үүдэн **залуучууд нийгэмдээ болон өөртөө итгэх итгэл алдарч**, бие даасан цаашилбал нийгмийг авч явах **бие хүн болон төлөвших үйл явц удаашралтай байгаа** нь хамгийн гол тулгамдаж буй асуудал болжээ гэж үзэж байна.

Залуучуудад чиглэсэн төрийн бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, түүнийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн авч буй арга хэмжээтэй танилцаж тус судалгааны ажилд тойм хэлбэрээр орууллаа. Манай улсын стратегийн чухал баримт бичгүүдэд залуучуудад чиглэсэн бодлогын олон арга хэмжээ тусгагддаг боловч түүний хэрэгжилтийн үр дүн, хамрах хүрээ бага байсаар байна. Энэ нь нэг талаас төсөл хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоо бага, хэрэгжүүлэх арга хэмжээний эрэмбэ, дэс дараалалыг тогтоохгүй олон үр ашиггүй ерөнхий ажлыг төлөвлөдөгтэй холбоотой бөгөөд нөгөө талаас үйл ажиллагааны санхүүжилт дутагдалтай буюу хязгаарлагдмал, хариуцлага хүлээх, хүлээлгэх зүйл заалт эдгээр баримтуудад нарийвчлан тусдаггүйтэй холбогдоно.

Иймд залуучуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэднийг **бие даасан хүн болгон хөгжүүлэх, дэмжих үрт хугацааны, шат дараалсан уялдаа холбоо бүхий төрийн бодлого, стратеги үгүйлэгдэж байгаа нь харагдана.**

Залуучуудад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллагын бүтэц салангид хэв маягтай, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо сул, заримдаа тэдний эрх үүрэг тодорхойгүй байгаа нь бодлого залуучуудад хүрэхгүй байх нэг нөхцөл шалтгаан болсоор байна.

Манай улсад залуучуудад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг нэлээд тооны төрийн бус байгууллагууд, эвсэл, холбоод үйл ажиллагаа явуулж байна. Гэвч **төрийн болон төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа сул хөгжсөн**, тэдний бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж бага байгаа болон **ихэнхи төрийн бус байгууллагад үйл ажиллагаа, санхүүгийн ил тод бус байдал ноёлж байгаа** нь анхаарч үзэх асуудлын нэг юм.

Залуучуудад автобусаар үнэгүй зорчих эрх, сургалтын төлбөрийн нэг удаагийн тусламж бус - бие даан ажиллаж, амьдрах чадвартай иргэн хүн болоход шаардлагатай тэгш боломж бололцоог бүрдүүлэх, нийгэмдээ, гэр бүлдээ, өөртөө итгэлтэй бие хүн болоход туслах төрийн ойлгомжтой, тодорхой дэмжлэг бодлого хэрэгтэй байна.

Залуучууд бол хүндрэл бэрхшээлтэй хүмүүс бус манай нийгмийг хөгжилд хүргэх боломж, нөөц бололцоо төдийгүй тулгуур багана болох учиртай билээ.

АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

Хууль тогтоомж, дүрэм журам

1. Монгол Улсын Их хурлын тогтоол /2008 он/
“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” батлах тухай
2. Монгол Улсын Их хурлын тогтоол /2008 он/
“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
3. Монгол Улсын Үндсэн хууль
4. Иргэний хууль. 2002 он
5. Эрүүгийн хууль. 2002 он
6. Хөдөлмөрийн тухай хууль. 1999 он
7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. 2001 он
8. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
9. Төрийн бус байгууллагын тухай хууль
10. Хүүхдийн эрхмийг хамгаалах тухай хууль. 1996 он
11. Гэр бүлийн тухай хууль. 1999 он
12. Эрүүл мэндийн тухай хууль. 1998 он
13. Дээд боловсролын тухай хууль. 2002 он
14. Хүний хөгжил сангийн тухай хууль. 2009 он
15. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль. 2009 он
16. Нийгмийн халамжийн тухай хууль. 2005 он
17. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль. 1994 он
18. ОУХБ: Олон улсын хөдөлмөрийн конвенц, зөвлөмжүүдийн эмхтгэл, Улаанбаатар, 1996
19. МУ-ын Засгийн газрын 282 дугаар тогтоол /2006 он/
“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлах тухай”
20. МУ-ын Засгийн газрын 25 дугаар тогтоол /1995 он/
“Ажилгүйдэл, ядуурлын байдалд улсын хэмжээний үзлэг явуулах тухай”
21. МУ-ын Засгийн газрын 84 дүгээр тогтоол /2010 он/
“Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар авах арга хэмжээний тухай”
22. МУ-ын Засгийн газрын 262 дугаар тогтоол /2003 он/
“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний тухай”
23. МУ-ын Засгийн газрын 69 дүгээр тогтоол /2009 он/
“Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2009-2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”
24. МУ-ын Засгийн газрын 43 дугаар тогтоол /2007 он/
“Хүүхэд бүрт мөнгө олгох тухай”
25. МУ-ын Засгийн газрын 261 дүгээр тогтоол /2008 он/
“Хүүхдийн төлөө сангийн дүрэм батлах тухай”

26. МУ-ын Засгийн газрын 03 дугаар тогтоол /2009 он/
“Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам батлах тухай”
27. МУ-ын Засгийн газрын 294 дүгээр тогтоол /2007 он/
“Мэргэжлийн сургалт- үйлдвэрлэлийн төвийн суралцагдад тэтгэлэг олгох тухай”
28. МУ-ын Засгийн газрын 174 дүгээр тогтоол /2010 он/
“Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх тухай”
29. МУ-ын Засгийн газрын 5 дугаар тогтоол /2009 он/
“Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай”
30. МУ-ын Засгийн газрын 24 дүгээр тогтоол /2002 он/
Хавсралт 2 “Оюутны жилд хийх ажлын төлөвлөгөө”
31. МУ-ын Засгийн газрын 21 дүгээр тогтоол /2004 он/
“Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай”
32. МУ-ын Засгийн газрын 174 дүгээр тогтоол /2010 он/
“Шинжлэх ухааны салбарыг дэмжих зарим арга хэмжээний тухай”
33. МУ-ын Засгийн газрын 139 дүгээр тогтоол /2003 он/
“Сургалтын төлбөрийн тухай”
34. МУ-ын Засгийн газрын 209 дүгээр тогтоол /2010 он/
“Сургалтын төлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
35. МУ-ын Засгийн газрын 177 дугаар тогтоол /2008 он/
“Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам батлах тухай”
36. МУ-ын Засгийн газрын 201 дүгээр тогтоол /2000 он/
“Төрийн албан хаагчийн гэр бүлийн 1 хүүхдийг төрөөс санхүүжүүлэх тухай”

Хөтөлбөр, бодлогын баримт бичгүүд

1. “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт Монголд” , Үндэсний илтгэл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ГХЯ, 2004 он
2. “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт” Үндэсний 2 дахь илтгэл, МУЗГ, СЯ, 2007 он
3. “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт” Үндэсний 3 дахь илтгэл, МУЗГ, ҮХШХ, 2009 он
4. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, МУЗГ, 2010 он
5. Монгол Улсын хүүхэд хамгааллыг бэхжүүлэх дунд хугацааны стратеги (2009 – 2014)
6. Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2007-2015)
7. Монгол Улсын Засгийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам: Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, Улаанбаатар, 2003
8. Монгол Улсын Засгийн газар: Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, Улаанбаатар, 2003
9. Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөр, 2003

10. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр: Монголын хүний хөгжлийн илтгэл, 1997, 2000, 2003, Улаанбаатар
11. “Монголын хүний хөгжлийн илтгэл 2007”. “Хөдөлмөр эрхлэлт, ядуурал” /хураангуй. УБ., 2007
12. Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал” Үндэсний илтгэл, 2006 он
13. “Монгол дахь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх ОУХБ-ын бодлогын чиглэлүүд”. ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэлтийн стратегийн хэлтэс. 2007
14. United Nations: Resolution adopted by the General Assembly, 58/133. Policies and programmes involving youth, 26 January 2004
15. United Nations: Resolution adopted by the General Assembly, 57/165. Promoting youth employment, 16 January 2003

Ном зохиол, судалгааны материал

1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа: 2008 он, МУҮСХ, ЭМЯ, 2009 он.
2. Үндэсний статистикийн газар: Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого: Монголын залуучууд, сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар, 2004
3. Үндэсний статистикийн газар, Азийн хөгжлийн банк: Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, Улаанбаатар, 2004
4. Монголын Залуучуудын Холбооны Залуучуудын хөгжлийн “Полиси” төв: “Монголын залуучуудын хөгжлийн хэрэгцээ” суурь судалгаа, Улаанбаатар, 2003
5. “Монголын залуучуудын хөгжлийн хэрэгцээ, 2002-2003” суурь судалгааны тайлан. МЗХ-ны Залуучуудын хөгжлийн Полиси төв. УБ., 2003
6. “Нийслэлийн залуучуудын хөдөлмөр эрхлэлт” МУИС Социологийн тэнхим. УБ., 1996
7. Антони Гидденс. “Социологи”. Орч ред: Д.Ганхуяг. УБ., 2006
8. В.Г.Криско. “Сэтгэл судлал” Бүдүүвч, хүснэгт. Орч: доктор, профессор Б.Туяа, доктор, профессор Л.Уранцэцэг. УБ., 2002
9. Х.Гүндсамбуу. “Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага”. УБ., 2002
37. “Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт”. Ред Ц.Уртнасан. УБ., 2001
38. ILO: Youth: Pathways to decent work, Report VI, International Labour Conference, 93rd session, 2005
39. ILO: Resolution concerning youth employment, adopted by the International Labour Conference at its 93rd Session, Geneva, June 2005

Интернет болон бусад материал

1. <http://www.factnews.mn/news/view/index/id/4231>
2. <http://biznetwork.mn/network/topic/show/8949/page/1>
3. http://ec.europa.eu/youth/youth-in-action-programme/doc74_en.htm
4. www.sonin.mn, 2009.09.21. “МЗХ-ны ерөнхийлөгч Ц.Зоригтбаатараас асуух асуулт” нийтлэл
5. <http://www.student.org.mn>
6. <http://www.jci.cc/local/mongolia-mn>
7. <http://www.scout.mn>
8. www.demyouth.mn
9. www.zaluus.mn,
10. www.izn.mn
11. www.yap.mn
12. <http://www.zorigfoundation.org.mn/>
13. www.statis.ub.gov.mn ”Нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд – 2008 он”. 2010/04/06